## ДУНДГОВЬ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН /ЖИЛИЙН ЭЦЭС/

**2025 оны 11 сарын 11**

2025 оныг Ёс зүй, хариуцлагыг сайжруулах жил болгон зарлаж Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ баримтлан сахилга хариуцлагатай, шинийг санаачлан ажиллахаар гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 28 арга хэмжээ тусган хэрэгжүүлж ажиллалаа.

УБЕГазраас албан бичгээр ирүүлсэн Даргын зөвлөлийн хурал, шуурхай хуралдаанаас ирүүлсэн 8 удаагийн үүрэг даалгавар, чиглэлийн хүрээнд холбогдох ажлуудыг зохион байгуулж тайлан мэдээг илтгэх хуудсаар хугацаанд нь өгч ажиллалаа.

### *1-РТ ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД:*

2025 оны тасгийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилтын хүрээнд 27 арга хэмжээ төлөвлөж арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллалаа.

*1-рт. УБЕГазрын Иргэний улсын бүртгэлийн газар, хэлтсийн даргаас өгсөн чиглэл, үүрэг даалгавар, зөвлөмжийн дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.*

ИУБГазрын даргын 2025 оны 01 сарын 09-ний өдрийн 3/432 тоот албан бичгийг хүлээн авч улсын бүртгэгчдэд танилцуулан 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс хойш хэвлэгдэн ирсэн 165 иргэний үнэмлэхийг шалгахад зөрчилтэй бүртгэл гараагүй тухай ИУБГазарт илтгэх хуудсаар хүргүүллээ. Харин иргэний үнэмлэхээ хаяж үрэгдүүлээд e-mongolia системээр дахин захиалсан 2 иргэний үнэмлэх хүчинтэй хугацаа нь буруу хэвлэгдэн монгол шуудангаар иргэдийн гар дээр ирсэн байсан. УБЕГазраас иргэдэд утсаар мэдэгдсэн гэж 2 иргэн цахим үнэмлэхээ авч ирснийг ИУБГазарт хүргүүлсэн.

ИУБГазрын даргын 2025 оны 1 сарын 20-ний өдрийн 3/1017 тоот албан бичгээр иргэний үнэмлэхийн хүчинтэй хугацаа алдаатай хэвлэгдэн ирж байгаагийн шалтгаан нь иргэдийг биеийн давхцахгүй өгөгдлийг бүртгэхдээ төлөв буруу сонгож байгааг анхаарах тухай зөвлөмжийг улсын бүртгэгчдэд танилцуулан мөрдөж ажиллах, алдаагүй үнэн зөв бүртгэл хөтлөхийг анхааруулլаа.

2 дугаар сарын 6-ны өдрийн имэйлээр 100 гаас дээш насны иргэдийн судалгааг шалгаж ирүүлэх тухай үүрэг даалгаврын хүрээнд тус аймгийн хэмжээнд 7 настан байгаа бөгөөд иргэний бүртгэлийн мэдээллийн сан болон аймгийн статистикийн хэлтсийн хүн амын өрхийн мэдээллийн сантай тулгахад бүгд хаяг дээрээ амьдарч байсан тул мэдээлэл шалгасан тухай жагсаалтыг албан тоотоор ИУБГазарт хугацаанд нь хүргүүлсэн.

2025 оны 07 сарын 31-ны өдрийн УБЕГазрын 4/9354 тоот албан бичгээр ирүүлсэн сургууль цэцэрлэгийн хүүхдийн бүртгэл эхэлж байгаатай холбоотой шилжилт хөдөлгөөний бүртгэлийн үйлчилгээ олон имонголиа-аар шилжилт хөдөлгөөний хүсэлт илгээсэн иргэдийн бүртгэлийг хуулийн хугацаанд шийдвэрлэж ажиллахыг чиглэл болгосон мэдээллийг улсын бүртгэгчдэд хүргэж ажилласан.

Иргэний улсын бүртгэлийн газраас 2025 оны 08 сарын 15-ны өдөр гадаад паспортын бүртгэл авч байгаа улсын бүртгэгчдийн судалгааг яаралтай ирүүлэх үүрэг

даалгаврын хүрээнд тус аймагт гадаад паспортын бүртгэл авч байгаа 5 улсын бүртгэгчийн судалгааг хугацаанд нь хүргүүллээ.

УБЕГазрын 2025 оны 6 сарын 25 ны 1/8305, ИУБГазрын 2025 оны 07 сарын 3-ныөдрийн 3/8699 тоот албан бичгээр ирүүлсэн мөрдөгчийн мэдэгдлийн хүрээнд улсын бүртгэгчдэд цахимаар сургалт зохион байгууллаа.

Аймгийн эрүүл мэндийн газраас 2025 оны 08 сарын 21-ний өдрийн 01/385 дугаартай албан бичгээр Эрүүл мэндийн яам, Үндэсний статистикийн хороо, УБЕГазрын хамтарсан ажлын хэсгээр 2016-2024 оны байдлаар төрөлт, нас баралтын бүртгэлд статистик мэдээллийн тулгалт хийх ажлын хүрээнд жагсаалтаар ирүүлсэн тус аймгийн нас баралтын 64,төрөлтийн 107 иргэний мэдээллийг иргэний бүртгэлийн мэдээллийн санд тулгалт хийж хүргүүллээ.

Аймгийн боловсролын газрын 2025 оны 07 сарын 23-ны өдрийн 01/247 тоот албан бичгээр МУЗГазрын 2025.04.30-ны өдрийн 215 дугаар тогтоолоор батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх, зээл эргэн төлүүлэх журам’’-ын 4.12.1 заалтын дагуу 52 иргэний мэдээллийг сүүлийн 3 жилд шилжилт хөдөлгөөн хийсэн эсэх мэдээллийг тулгаж ирүүлэх хүсэлтийн дагуу мэдээллийн санд тулгалт хийж хүргүүллээ.

Иргэний улсын бүртгэлийн маягтын талаар хэрэгжүүлэх арга хэмжээний тухай 2025 оны 10 сарын 7-ны өдрийн 9/11600 тоот албан бичгийг улсын бүртгэгч нарт танилцуулан чиглэлийн талаар холбогдох ажлын зохион байгуулан ажилласан.

*2025 оны нөхөн сонгуулийн ажлын хүрээнд*

Орон нутгийн нөхөн сонгуулийн тов зарласан тухай Сайхановоо, Адаацаг, Өлзийт сумдын ИТХурлын тогтоолыг ИУБГазарт хүргүүлсэн. Election.gasr.mn системд эрх нээлгэн нөхөн сонгуулийн тов зарласан тухай тогтоолыг шивж оруууллаа.
ИУБГазраас 2 сарын 11 ны өдөр зохион байгуулсан иргэний улсын бүртгэл хөтлөхдөө Улсын бүртгэлийн хууль тогтоомж, Авлигын эсрэг хууль бусад хууль тогтоомжийн талаарх сургалтад 4 албан хаагч хамрагдлаа.Мөн сургалтын файл болон мэдээллийг улсын бүртгэгчдэд цахимаар хүргэсэн.

Аймаг нийслэл сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын оны 2025 нөхөн сонгууль тус аймгийн Адаацаг сумын 4-р баг Сүм, Өлзийт сумын 4-р баг Дэрт -1, Сайхановоо сумын 2-р баг Мааньт хэсэгт тус тус явагдана. Нөхөн сонгуулийн тов зарласан тухай дээрх сумдын ИТХурлын тогтоолыг ИУБГазарт цахимаар хүргүүлсэн. Election.gasr.mn программд нөхөн сонгуулийн тов зарласан тухай тогтоолыг 2025 оны 02 сарын 13,14 –ний өдрүүдэд программд шивж цахимжуулсан. Иргэний улсын бүртгэлийн газраас өгсөн чиглэлийн дагуу санал авах байрны бүртгэлийг 2024 оны 10 сард болсон АНСДИТХурлын ээлжит сонгуулийн мэдээллээс хуулан баталгаажуулт тулгалт хийсэн.

Сонгогчдын нэрийн жагсаалтыг тулгах явцад 2024 оны 10 сараас 2025 онд шилжин ирсэн иргэдийн нэр орхигдсон, нас барсан иргэдийн нэр сонгогчдын нэрийн жагсаалтад байсныг ИУБГазарт мэдэгдсэн. Өнөөдрийн байдлаар 2024-2025 онд Адаацаг сумын 4-р багт шилжин ирсэн 13 иргэн, Сайхановоо сумын 2-р багт шилжин ирсэн 4 иргэн, Өлзийт сумын 4-р багт шилжин ирсэн 3 иргэн нийт 20 иргэн нэмэгдэж орсон, нас барсан сонгогчийн хасагдсан өөрчлөлтүүд тусгагдсан байна. Адаацаг 4-р баг 397, Өлзийт Дэрт 4-р баг 223, Сайхановоо 2-р баг Мааньт 300 сонгогч нийт 920 сонгогч бүртгэлтэй байна.

Аймаг нийслэл сум дүүргийн ИТХурлын 2025 онын нөхөн сонгууль тус аймгийн Адаацаг сумын 4-р баг Сүм /397 сонгогч /, Сайхановоо сумын 2-р баг Мааньт /297 сонгогч/, Өлзийт сумдын 4-р баг дэрт 1 /223 сонгогч/ багуудад явагдана. Сонгуулийн тухай хуульд заасны дагуу санал авах өдрөөс 60 аас доошгүй хоногийн өмнө засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжин суурьших хөдөлгөөний бүртгэлийг түр хугацаагаар зогсооно гэж зааны дагуу иргэний шилжилт хөдөлгөөн 2025 оны 04 сарын 23-ны өдрөөс эхлэн түр хугацаагаар зогслоо.

Нөхөн сонгууль явагдах 3 хэсэгт сонгуулийн хуулийн 20,6,1 д заасан эрх зүйн чадамжгүй төлөвтэй 3 , 20,6,3 д заасан гадаадад 60 хоногоос дээш хугацаагаар зорчсон төлөвтэй 14 , 20,6,2 д заасан хорих ангид төлөвтэй 1, 20,6,6 цагдаагийн алба хаагч дотоодын цэргийн анги төлөвтэй 1 нийт 19 сонгогчид төлөв оноогдсон байна. Гадаадад 60 хоногоос дээш хугацаагаар зорчсон төлөвтэй 14 иргэдээс Сайхановоо сумын 2 дугаар баг мааньт багийн иргэн Лхагваосорын Батзаяа /зл03230519 /, Адъяадорж Бүдханд /зл73040401 / нар нь одоо хаяг дээрээ байгаа гэсэн мэдээллийг ирүүлсэн бусад мэдээлэл нь зөрүүгүй байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.9 дэх хэсэг, Сонгуулийн ерөнхий хорооны 2025 оны 01 тоот тогтоолоор баталсан ''Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөө''-нд заасны дагуу сонгогчдын нэрийн жагсаалтыг 2025 оны 5 дугаар сарын 16-ний өдөр хэвлэлээ. Сонгогчдын нэрийн жагсаалтад хэсэг оноогдоогүй сонгогч байгааг нягтлан шалгасан бөгөөд хэсэг оноогдоогүй сонгогч байгаагүй. Сонгогчдын нэрийн жагсаалтыг 2 хувь хэвлэж хэлтсийн дарга, хяналтын улсын байцаагчаар хянуулж тамга тэмдгээр баталгаажуулан нэг хувийг дугтуйлж хэсгийн хороонд актаар хүлээлгэн өгч нэг хувийг хэлтэст авч үлдлээ.

Адаацаг сумын 4-р баг Сүм 396 сонгогч, Өлзийт сумын 4-р баг Дэрт 2 баг 226 сонгогч, Сайхановоо сумын 2-р баг Мааньт 296 сонгогч нийт 918 сонгогч бүртгэгдсэн бөгөөд түр хасав тэмдэглэгээтэй 20 сонгогч байлаа.

*2-рт Иргэний бүртгэлийн чиглэлээр:*

2025 оны тайлант хугацаанд 14688 иргэнд иргэний улсын бүртгэлийн үйлчилгээг хүргэлээ. Тайлант хугацаанд ИГББүртгэлийн сар бүрийн тоон мэдээний нэгтгэлийг 10, инфографик мэдээ 10 удаа гаргаж өгсөн. Иргэний бүртгэлийн санд мэдээлэл тусгагдаагүй, мэдээлэл засуулах хүсэлтэй, регистрийн дугаар буруу олгогдсон зэрэг 17 иргэний өргөдөл гомдлыг хүлээн авч хугацаанд нь шийдвэрлэж ажиллалаа.

Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд 1557 иргэн бүртгэлд хамрагдсан бөгөөд 16 насанд хүрч бүртгэлд хамрагдсан 622 иргэн, 25, 45 насны сунгалтаар 935 иргэн хамрагдсан байна. Нийт 1716 иргэний үнэмлэх хэвлэгдсэн ирж иргэдэд олгогдсон.

2025 оны байдлаар 3900 иргэнд тоон гарын үсэг олголоо. Тоон гарын үсгийг 588 иргэнд иргэний үнэмлэхийн чипэнд, 3312 иргэний гар утсанд gsign аппликейшн суулган олгосон байна. Нийт 26826 иргэнд тоон гарын үсэг олгож 83,7 хувьтай байна. Киоск машинаас 1397 иргэн тоон гарын үсэг авсан байна. УБЕГазрын ИУБГазраас ирсэн 3/10321 тоот чиглэлийн дагуу тоон гарын үсгийг олгохдоо иргэний үнэмлэх, гарын хурууны хээг төхөөрөмжөөр уншуулан тоон гарын үсгийг олгож байна. Эрүүл мэндийн шалтгааны улмаас хурууны хээ уншигдахгүй байгаа 88 иргэнд тоон гарын үсгийг регистрийн дугаараар олгосон. Тайлант хугацаанд төрөлтийн бүртгэлд 549 хүүхэд, гэрлэлтийн

бүртгэл 103, үрчлэлт 14, гэрлэлт цуцлалтын бүртгэл 43, эцэг тогтоолтын бүртгэл 24 , ОНӨ бүртгэл 31, нас барсны бүртгэлд 243 нийт иргэний гэр бүлийн бүртгэлийн 1007 бүртгэл, 1754 иргэн шилжилт хөдөлгөөний бүртгэлд, үндэсний энгийн гадаад паспорт 2069, иргэний үнэмлэхийн бүртгэлд 1793 , нэмэлт өөрчлөлтийн бүртгэлд 462 нийт 7085 бүртгэл хөтлөн иргэний бүртгэлийн санд мэдээллийг баталгаажуулсан байна.




Эрүүл мэндийн яамны мэдээллийн сангаас 549 хүүхдийн регистрийн дугаарыг унагаж төрсний бүртгэлд бүртгэсэн бөгөөд 280 эрэгтэй, 269 эмэгтэй хүүхэд төрсний бүртгэлд бүртгэгдсэн байна. Нийт төрсөн хүүхдийн 66,4 хувь буюу 365 хүүхэд Сайнцагаан суманд төрсний бүртгэлд бүртгэгдсэн байна. Эрүүл мэндийн яамны мэдээллийн санд регистрийн дугаар хүйс зөрүүлж бүртгэсэн нэг иргэний бүртгэлийг аймгийн төрөх тасагт хүргүүлэн ЭМДГазрын мэдээллийн сангаас устгуулж дахин регистрийн дугаараар төрөлтийн бүртгэлд хамруулллаа. Төрсөн эхчүүдийг насны бүлгээр авч үзвэл 15-19 насны 28, 20-24 насны 120, 25-29 насны 155, 30-34 насны 135, 35-39 насны 92, 40-44 насны 18 эмэгтэй төрсөн байна. Батлуулсан гэр бүлтэй 240 эмэгтэй, батлуулаагүй гэр бүлтэй 131 эмэгтэй төрж, бүрэн дунд боловсролтой 223, дээд боловсролтой 205 эх төрсөн нь нийт төрсөн эхчүүдийн 77,9 хувь байна.

Нийт 3703 лавлагаа хэвлэсэн бөгөөд хууль хяналтын байгууллагын хүсэлтээр 332 шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүсэлтээр 91, Дундговь аймаг дахь сум дундын шүүхэд 116, прокурорын хүсэлтээр 69, цагдаагийн байгууллагын хүсэлтээр 28, Авилгатай тэмцэх газар 30 лавлагаа олгожээ. Хууль хяналтын байгууллагад олгосон лавлагааг өнгөрсөн оны хагас жилийн байдалтай харьцуулахад 50 хувиар бага байна. Мөн авч байгаа лавлагааны дийлэнх буюу 75,9 хувийг иргэний оршин суугаа газрын хаягийн лавлагаа эзэлж байна.

Албан хэрэгцээнд улсын бүртгэгчид 1365 лавлагааг хэвлэж, иргэний хүсэлтээр 2006 лавлагаа олгосон байна. Төрсний лавлагаа 789, цахим үнэмлэх 1448, гэрлэсний лавлагаа 266 байгаа нь нийт лавлагааны 67,6 хувь байна.

Тайлант хугацаанд 1754 иргэн шилжин ирсний бүртгэлд гадны аймаг хотоос шилжин ирсэн 16-аас дээш насны 340 иргэн, 16-аас доош насны 271 иргэн, аймаг доторх шилжилт хөдөлгөөн сумаас суманд 16-аас дээш насны 223 иргэн, 16-аас доош насны 260

иргэн, багаас багт шилжсэн 16-аас дээш насны 320 иргэн, 16-аас доош насны 340 иргэн шилжилт хөдөлгөөний бүртгэл хийлгэсэн байна. Шилжин ирсэн иргэдийн 303 буюу 49.6 хувь нь Улаанбаатар хотоос шилжин иржээ.

Энэ хугацаанд тус аймгаас нийслэл болон бусад аймагт шилжин явсан 16-аас дээш насны 823 иргэн, 16-аас доош насны 576 иргэн нийт 1399 иргэн шилжилт хөдөлгөөний бүртгэлд хамрагдсан байна. Улаанбаатар хот руу 16-аас дээш насны 511, 16-аас доош насны 320 нийт 831 иргэн шилжсэн нь нийт шилжин явсан иргэдийн 59,3 хувийг эзэлж байна.




2025 онд гадаад паспортын үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, шат дамжлагыг бууруулах зорилгоор гадаас паспортын үйлчилгээ үзүүлж байгаа нэгжийг нэмэгдүүлж бүх сумдад гадаад паспортын бүртгэлийн эрхийг нээлгэлээ. Үүнтэй холбоотой тус сумдын улсын бүртгэгчдийг хэлтсийн нэг цэгийн үйлчилгээн дээр гадаад паспортын бүртгэлээр дадлага хийлгэж зөвлөмж арга зүйгээр хангаж ажилласан. Гадаад паспорт авах хүсэлтийн дагуу 2069 иргэнд гадаад паспортын үйлчилгээг хүргэсэн бөгөөд 1438 иргэнд шинээр, 631 иргэнд дахин олголоо. Гадаад паспортын материалын цахимжуулалтаар 2035 гадаад паспортын мэдээллийг цахимжуулж, 35 гадаад паспортын мэдээлэл цахимжаагүй байна.

Дэрэн сумын улсын бүртгэгч ажлаас чөлөөлөгдсөн, Хулд, Гурвансайхан сумд улсын бүртгэгчгүй байгаатай холбоотой анхан шатанд бүртгэлийн үйлчилгээг тасралтгүй хэвийн явуулах нөхцлийг бүрдүүлэн харъяалал харгалздаг бүртгэлийг хэлтсийн улсын бүртгэгч Ш Чулуунжаргал, Ё.Батбаяр, Ш.Чулуун нарт бүртгэлийн эрхийг нээлгэж бүртгэлийн үйлчилгээг хэвийн явуулах нөхцлийг бүрдүүлэн ажиллаж байна.

Улсын бүртгэгчдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх, бүртгэл хийх ур чадварыг нэмэгдүүлэх, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор Сайнцагаан сумын улсын бүртгэгчийг ээлжийн амралттай уялдуулан Дэлгэрцогт сумын улсын бүртгэгч Г.Намжим 1 сарын хугацаанд улсын бүртгэлийн хэлтсийн нэг цэгт бүртгэлийн үйлчилгээг иргэдэд хүргэж ажиллалаа.

Нэмэлт өөрчлөлтийн бүртгэлээр мэдээллийн санд төрөлт, овог нэр өөрчлөлт, эцэг тогтоолт, үндсэн мэдээллийн санд гэрлэлтийн төлөв буруутай орсон зэрэг 238 бүртгэлийг

хяналтын улсын байцаагчийн 6839 болон 4865 тоот дүгнэлтүүдийг үндэслэн засвар оруулсан. Мөн журнал бүртгэл, мэдээллийн санд эх нотлох баримт нь байгаа боловч мэдээлэл нь шивэгдэж ороогүй 227 бүртгэлийг нөхөн бүртгэлээр тухай бүрд оруулж байгаа нь үйлчилгээний шат дамжлага буурахаас гадна иргэдийн цаг хугацаа, эдийн засгийг хэмнэсэн үйлчилгээ болж чадаж байна.

Тайлант хугацаанд улсын бүртгэгчдээс иргэний улсын бүртгэлийн маягт гэрчилгээг техникийн алдаанаас 9, бүртгэгчдийн алдаанаас 61 ш нийт 70 ш үнэт цаасыг хүчингүй болгосон байна. Үүнд: Төрсний гэрчилгээ 12, гэрлэлтийн гэрчилгээ 2, нас барсны гэрчилгээ 4, үндсэн бүртгэл 23, ИУБ-31 маягт 16 ш, шилжилт хөдөлгөөний 5 үнэт цаас байна. Хүчингүй болгож байгаа үнэт цаасны тоо буурсан үзүүлэлттэй байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны 06 сарын 08-ны өдрийн А/341 тоот тушаалаар батлагдсан ''Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журам ''-ын 5.1.1-д заасны дагуу тус хэлтсийн хяналтын улсын байцаагч сумын улсын бүртгэгч нарын улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаа болон түүнтэй холбоотой бусад үйл ажиллагаа, 2025 оны 02 дугаар сарын тоон мэдээ болон үнэт цаасны тайланд хяналт хийсэн. Энэ шалгалтаар Эрдэнэдалай, Адаацаг, Дэрэн сумдын тайлан алдаагүй бусад сумдын улсын бүртгэгчдийн гаргаж байгаа мэдээ тайлан зөрүүтэй, хүчингүй үнэт цаасны тайлан хугацаа хоцроож гаргаж өгдөг зэрэг зөрчил дутагдлыг арилгах тухай 2025 оны 03 сарын 15 ны өдрийн 05 тоот хяналтын улсын байцаагчийн мэдэгдлийг авсан.

Хяналтын улсын байцаагчийн мэдэгдлийн хүрээнд нярваас үнэт цаасны зарцуулалтын талаарх 1-3 сарын тоон мэдээ, хүчингүй болгосон үнэт цаасны мэдээ, үнэт цаасны программд хүчингүй болгосон үнэт цаасны хүсэлт илгээсэн жагсаалт зэргийг гаргуулан авч тулгалт хийлээ. Улсын бүртгэгчид иргэний гэр бүлийн тайлан мэдээгээ үнэт цаасны тайлантайгаа тулгалт хийж гаргадаггүй, бүртгэл хийхдээ үнэт цаасны дэс дарааллын дагуу авч ашигладаггүй, үнэт цаасны программд хүчингүй үнэт цаасаа шивдэггүй, нярав, нягтлантай тооцоог сар бүр нийлж баталгаажуулдаггүйгээс мэдээ тайланг зөрүүтэй гарч байсан тул хугацаатай үүрэг даалгавар өгч ажилласан.

Улсын бүртгэлийн цахимаар үзүүлж байгаа үйлчилгээ, улсын бүртгэгчдийн бүртгэсэн бүртгэлийн тоо, бүртгэгчдийн ажлын ачаалал зэрэгт өгөгдлийн шинжилгээг хийлээ. Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр тайлант хугацаанд хийж гүйцэтгэсэн статистик бүртгэлийн тоон мэдээний үзүүлэлтээс 13 сумын улсын бүртгэгчийн бүртгэсэн ИГББүртгэлийн 1007, иргэний үнэмлэхийн 1793, шилжилт хөдөлгөөний 1754, иргэдэд олгосон лавлагаа 2304 нийт 6858 бүртгэлд харьцуулалт хийж үзэхэд нэг бүртгэгч ажлын 1 өдөрт дунджаар 17 бүртгэл хийж байна. Бүртгэгч тус бүрээр үзэхэд Сайнцагаан сумын улсын бүртгэгч 3950 буюу нийт бүртгэлийн 57,6 хувийг эзэлж байгаа бол хамгийн бага бүртгэлийг Өлзийт сумын улсын бүртгэгч 70 бүртгэл буюу нийт бүртгэлийн 1 хувийг эзэлж байна.

Улсын бүртгэлийн үйлчилгээний киоск машин болон төрийн үйлчилгээний хурдан системээс авсан үйлчилгээний тоог харуулбал төрийн үйлчилгээний хурдан системээс иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 6935 бүртгэлийн лавлагаа мэдээлэл, киоск машинаас 3328 лавлагаа нийт 10263 бүртгэлийн үйлчилгээг цахимаас гарсан байна. Бүртгэлийн үйлчилгээний төрлөөр авч үзэхэд цахим үнэмлэхийн лавлагаа 5950, хаягийн лавлагаа 2730, төрсний бүртгэлийн лавлагаа 920, гэрлэлтийн лавлагаа 458 иргэний үнэмлэхийн захиалга 85 бусад төрлийн лавлагаа 120 байна.

Цахимаас авч байгаа үйлчилгээний дийлэнх буюу 98 хувь нь лавлагаа эзэлж байгаа бөгөөд цахимаар улсын бүртгэл хийлгэж байгаа тоо байхгүй байгаа нь мэдээлэл хангалтгүй, иргэдийн цахим хэрэглээ, интернэт орчинд ажиллах чадвар дутмаг байна гэж харагдаж байна.Мөн төрийн үйлчилгээний хурдан системээс авсан үйлчилгээний тоо

бүртгэлийн киоск машинаас авсан тооноос 1 дахин их байна.

*Иргэний бүртгэлийн архивын талаар*

Тайлант хугацааны ИГББүртгэлийн нийт 791 бүртгэлийн иргэний улсын бүртгэлийн маягт, биеийн давцахгүй өгөгдлийн 1056 ИУБ-31 маягт, шилжилт хөдөлгөөний бүртгэлийн 719 нийт 2566 маягтыг архивт хүлээлгэн өглөө. Иргэний гэр бүлийн бүртгэлийн А тал 729 ш маягт, ИУБ-31 маягтын А тал 697 ш нийт 1426 маягтыг УБЕГазрын иргэний баримтын архивт хүргүүлсэн бол шилжин ирсэн 130, шилжин явсан 711 иргэний хувийн хэргийг холбогдох аймгуудад хүргүүлж ажилласан. Улсын бүртгэлийн мэдээллийн сангийн эх нотлох баримтыг цахимжуулах ажлын хүрээнд тайлант хугацаанд иргэний гэр бүлийн 1007 бүртгэлийн 5035 цаасан нотлох баримт, шилжилт хөдөлгөөний 1754, гадаад паспортын 2069, иргэний үнэмлэхийн 1793 нийт 5616 бүртгэлийн 22464 цаасан нотлох баримт нийт 6623 бүртгэлийн 27499 нотлох баримтыг цахимжууллаа

Улсын бүртгэлийн нэгдсэн архивын даргын 2024 оны 6 сарын 25-ны өдрийн 9/8570 тоот албан бичгээр иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийг цахимжуулах тухай үүрэг даалгаврын хүрээнд 2020-2021 оны төрөлтийн 2492 хувийн хэргийг цахимжууллаа. Улсын бүртгэлийн нэгдсэн архивын даргын 2024 оны 6 сарын 25-ны өдрийн 9/8570 тоот албан бичгээр иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийг цахимжуулах тухай үүрэг даалгаврын хүрээнд 2020-2021 оны төрөлтийн 3292 хувийн хэргийг цахимжууллаа. Мэдээллийн сан цэгцлэх тухай 2025 оны 04 сарын 09-ний өдрийн 9/4990 тоот чиглэлээр мэдээллийн санд хөрвүүлэлтийн алдаатай 499 төрөлт, 701 гэрлэлт, 505 нас баралт нийт 1705 бүртгэлийн жагсаалт ирсэн.

Үүнээс архивын санд шалгахад 412 хувийн хэрэг цахимжсан байна. Шилжин явсан 367 иргэний хувийн хэрэг байхгүй байгаа бөгөөд шилжин явсан аймгуудад жагсаалтаар хүргүүлэн цахимжуулсаны дараа хөрвүүлэлт хийгдэж байна. Мэдээллийн санд нийт 450 иргэний мэдээллийг нэмэлт өөрчлөлтийн бүртгэлээр оруууллаа. Тайлан мэдээг архивын газраас ирүүлсэн хүснэгтийн дагуу сар бүр хүргүүлж байна.

*4-рт Сургалт, сурталчилгаа:*

Улсын бүртгэгчдийг мэргэжил арга зүйгээр хангах ажлын хүрээнд иргэний бүртгэлийн тасгийн яриаг 3 удаа хийсэн. Өндөршил, Дэлгэрцогт сумдын улсын бүртгэгчид шинээр томилогдсонтой холбогдон ажлын байрны дадлага өгөх программын сургалтыг Сайнцагаан сумын улсын бүртгэгч Ш. Чулуун, иргэний улсын бүртгэлийн хууль журам, анхаарах асуудлаар ахлах бүртгэгч нар заавар зөвлөмж өгч ажиллалаа. Шинээр томилогдож байгаа улсын бүртгэгчдэд хүний нөөцийн сургалтын системийг хэрхэн ашиглах, улсын бүртгэлийн хууль тогтоомж, дүрэм журам зэргийг хэрхэн судалж эзэмшиж өөрийн мэдлэг чадвараа байнга сайжруулж ажиллах талаар зөвлөгөө зөвлөмжийг өгч ажиллаж байна. Мөн Алдарт эхийн одонгийн журамтай холбоотой төрсний бүртгэл нь иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сан болон журнал бүртгэлд байгаа боловч нас барсны бүртгэлд бүртгүүлээгүй тохиолдол гарч байгааг улсын бүртгэгчдэд анхааруулж заавар зөвлөмж өгч ажиллалаа. Хяналтын улсын байцаагчийн Мэдэгдлийн хүрээнд улсын бүртгэгчдэд үнэт цаасны зарцуулалт, иргэний гэр бүлийн статистик тоон мэдээ гаргах, иргэний бүртгэлийн системд үнэт цаасны бүртгэлийг хэрхэн хийх талаар арга зүйн зөвлөмж өгөх сургалт хийх тухай дотоод албан бичгийг улсын бүртгэгчдэд хүргүүлэн 4 сарын 7-ны өдөр сургалтыг цахимаар зохион байгууллаа. Сургалтад 11 бүртгэгч хамрагдсан.

Улсын бүртгэлийн үйлчилгээг өөрийн биеэр ирж авах боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настан хэвтрийн асаргаанд байдаг гэх мэт зорилтот бүлгийн иргэдэд тус хэлтсээс зөөврийн төхөөрөмж ашиглан хөдөлгөөнт хэлбэрээр бүртгэлийн үйлчилгээг хүргэж байна. Тайлант хугацаанд зөөврийн төхөөрөмжөөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 2 удаа, Сайнцагаан сумын 7-р багт, Баянжаргалан, Говьугтаал, Цагаандэлгэр, Өндөршил, Дэрэн, Луус, Дэлгэрхангай зэрэг сумдын иргэдтэй хийсэн уулзалт өдөрлөгт 8 удаа, Сайнцагаан сумын 6 дугаар багийн өндөр настанд шилжилт хөдөлгөөний бүртгэлийг 1 удаа, Дэрэн, Баянжаргалан, Дэлгэрцогт сумдын улсын бүртгэгчид тус бүр 1 удаа, Хуульчдын ''Поро бона-2025'' өдөрлөгт'' 1 удаа нийт 15 удаа иргэний бүртгэлийн үйлчилгээг зөөврийн төхөөрөмжөөр хөдөлгөөнт хэлбэрээр хүргэсэн бөгөөд нийт 250 иргэнд үйлчилгээ үзүүллээ.

Аймгийн Засаг дарга тамгын газраас 2025 оны 05 сарын 12-19 ний өдрүүдэд Өндөршил, Баянжаргалан, Дэрэн, Цагаандэлгэр сумдад зохион байгуулсан ''Асуудал-шийдэл'' иргэдтэй хийсэн уулзалт өдөрлөг, 9 сарын 4-5 ны өдрүүдэд Говь-угтаал, Гурвансайхан сумдад зөөврийн 4 жи төхөөрөмжөөр 150 иргэнд гадаад паспорт, тоон гарын үсэг, лавлагаа, төрөлт зэрэг бүртгэлийн үйлчилгээг үзүүллээ.

Дэлгэрхангай суманд зохион байгуулагдсан ''Нутгийн хөгжилд бидний оролцоо'' малчдын өдөрлөгт оролцон зөөврийн 4 жи төхөөрөмжөөр 35 иргэнд бүртгэлийн үйлчилгээ хүргэлээ. Үүнд гадаад паспортын захиалга 24, тоон гарын үсэг 6, төрөлтийн бүртгэл 2, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд 4 иргэнийг хамрууллаа.

ШШГүйцэтгэх байгууллагын хүсэлтээр тус газар хоригдож байгаа Өвөрхангай аймгийн нэг иргэнийг биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл, мөн нэг иргэний гэрлэлтийн бүртгэлийг зөөврийн төхөөрөмжөөр бүртгэлээ.

2025 оны 05 дугаар сарын 01-ний өдөр аймгийн “МАНДАЛ” худалдааны төвийн талбайд зохион байгуулагдсан Хуульчдын “Про Боно” нээлттэй хаалганы өдөрлөгт оролцож 59 иргэнд иргэний бүртгэлийн үйлчилгээг хүргэлээ. Үүнд гадаад паспортын захиалга 9, тоон гарын үсэг 4, гадаад паспортын олголт 28, лавлагаа 3, мэдээлэл зөвлөгөө 15 иргэнд хүргэсэн.

Иргэн бүрийг гадаад паспорттой болгох, иргэд яарч сандарсан эсвэл хэрэгцээ нь гарах үед биш бичиг баримт бэлэн байх ямар ач холбогдолтойг иргэдэд сурталчлах зорилгоор 2025 оны 3 сарын 29-нд '' Та аялахдаа бэлэн үү'' гадаад паспортын өдөрлөгийг Улсын бүртгэлийн хэлтсийн нэг цэгийн үйлчилгээний танхимд зохион байгууллаа. Тус өдөрлөгөөр 15 иргэн гадаад паспорт захиалж, хэвлэгдэн ирсэн гадаад паспортыг 12 иргэнд олгосон байна.

Иргэний улсын бүртгэлийн газар болон Хяналт шалгалтын газраас ирүүлж байгаа зөвлөмж, чиглэл, мэдэгдэл зэргийг хяналтын улсын байцаагчтай хамтран тухай бүр улсын бүртгэгчдэд мэдээлэл өгөх сургалтыг цахимаар зохион байгуулан ажиллаж байна. Авилгатай тэмцэх газрын 2025 оны 06 сарын 24-ний өдрийн 90 дугаартай, 2025 оны 07 сарын 03-ны өдрийн 3/8699 дугаартай Мөрдөгчийн мэдэгдлийн хүрээнд Хяналтын улсын байцаагч Д.Нямсүрэн, ахлах бүртгэгч нар хэлтсийн албан хаагч, улсын бүртгэгчдэд цахимаар танилцуулан улсын бүртгэлийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, улсын бүртгэлийн хууль тогтоомжийн дагуу иргэний бүртгэлийн системд тухайн иргэнийг өөрийн биеэр ирээгүй тохиолдолд бүртгэл хийхгүй байх, зөвхөн хурууны хээ уншуулж

улсын бүртгэл хөтлөх талаар анхааруулж гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр цахим сургалтыг зохион байгууллаа.

УБЕГазрын 2025 оны 06 сарын 25-ны өдрийн 1/8305 тоот зөвлөмжийн хүрээнд иргэний улсын бүртгэлийн тасгаас улсын бүртгэгчдэд чиглэл өгөх сургалтыг цахимаар зохион байгууллаа.Сургалтаар гэрлэлт дуусгавар болсны бүртгэл хөтлөхөд анхаарах асуудлаар улсын ахлах бүртгэгч Б. Сайхантуяа, 'Шүүхийн шийдвэрийн хуулийн хүчин төгөлдөр хугацааг анхаарах '' асуудлаар хяналтын улсын байцаагч Д. Нямсүрэн нар мэдээлэл өглөө. Гэр бүлийн тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Иргэний улсын бүртгэл хөтлөх журам зэрэг холбогох хууль тогтоомжийг мөрдөж ажиллахаас гадна иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сан, архивын санд бүртгэл хийхээс өмнө заавал нягтлан шалгах, өргөдлийн шаардлагыг хангуулж дэлгэрэнгүй бичүүлж байх, шүүхийн шийдвэрийн хүчин төгөлдөр хугацаа гэдгийг хэрхэн ойлгох, итгэмжлэл болон шүүхийн шийдвэрийн нэхэмжлэлийн шаардлага, тогтоох хэсгийн утга агуулгыг бүрэн гүйцэт уншиж танилцан үнэн зөв бүртгэл хөтлөхөд анхаарч ажиллах талаар үүрэг даалгавар, мэдээлэл арга зүйн зөвлөмж өглөө. Сургалтад нийт 12 албан хаагч хамрагдлаа.

Аймгийн Засаг дарга түүний тамгын газраас 'Асуудал шийдэл'' төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх, иргэдтэй хийх уулзалтыг 2025 оны 9-р сарын 4-5, 10 сарын 6-9 ны өдрүүдэд баруун зүүн сумдад зохион байгуулсан. Тус өдөрлөгөөр улсын бүртгэлийн хэлтсээс зөөврийн төхөөрөмжөөр улсын бүртгэлийн үйлчилгээг 230 иргэнд үзүүллээ.

Өлзийт суманд 2025 оны 11 сарын 4-нд зохион байгуулагдсан малчны өдөрлөгт оролцон улсын бүртгэлийн үйлчилгээг 25 иргэнд үзүүллээ.

/ Тоон мэдээ 11 сарын 9-ний өдрийн байдлаар тусгагдсан/

## 2-РТ ХЭЭХЭУБҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД:

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын даргын бичгээр ирүүлсэн 12 албан даалгавар, чиглэл, зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллаж хариуг илтгэх хуудсаар хугацаанд нь хүргүүллээ. 04 дүгээр сарын 1-14-ны өдрүүдэд эд хөрөнгийн эрхийн ахлах бүртгэгч болон бүртгэгч нарын ажлын байрыг сольж 7 хоногоор ээлжлэн, тасгийн даргыг нэг цэгийн үйлчилгээний танхимд ажиллуулсан ба бүртгэгч нар дээрх хугацаанд 136 бүртгэлийг хүлээн авч бүртгэсэн байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлж байгаа аймгийн төвийн 2, сумын 4 бүртгэгчийн 2025.01.01-2025.06.30-өдрүүдэд бүртгэсэн бүртгэлд өгөгдлийн шинжилгээ хийсэн. Тус хугацаанд нийт 1842 бүртгэл хүлээн авч боловсруулсан бөгөөд аймгийн төвийн 2 бүртгэгч тус бүр 757, 784, сумын бүртгэгчид 3,8,13,17 буюу 1 бүртгэгчийн 1 сард бүртгэсэн бүртгэлийн тоо аймгийн төвд 126-131, өдөрт бүртгэсэн бүртгэлийн тоо 6.0-6.2, сумын бүртгэгчийн сарын дундаж 1.0-2.8 байна.

## ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

Улсын бүртгэлийн хуулиар хүлээсэн үүргийн хүрээнд улсын бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, улсын бүртгэгч нарын өдөр тутмын үйл

ажиллагааг мэргэжил арга зүйгээр хангах, хяналт тавих, улсын бүртгэлийн эх нотлох баримтын үнэн зөвийг хангаан цахим болон цаасан мэдээллийн санг эрхлэн хөтлөх, хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг хангах, улсын бүртгэл алдаагүй, үнэн зөв байх байдлыг хангах чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна.

2025 оны 11 сарын 10-ны өдрийн байдлаар Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн нийт 3240 мэдүүлэг хүлээн авч бүртгэсэн байна. Үүнд: төрөөс хувьчилсан газрын анхны бүртгэл 502, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн анхны бүртгэл 285, шинээр баригдсан орон сууцны анхны бүртгэл 145, худалдах худалдан авах гэрээ 474, бэлэглэх гэрээ 117, өв залгамжлалаар өмчлөгч өөрчлөгдөх 78, шүүхийн шийдвэрээр өмчлөгч өөрчлөгдөх 2, бусад эрх шилжүүлэх бүртгэл 5, барьцааны гэрээний бүртгэл 916, барьцааны гэрээ дуусгавар болгох 645, түрээсийн гэрээ 4, үрэгдүүлсэн гэрчилгээ шинээр олгох 21, эд хөрөнгийн хаяг өөрчлөгдөх 59, эд хөрөнгийн зориулалт өөрчлөгдөх 3, эд хөрөнгийн хэмжээ үнэ гүйцэтгэл өөрчлөгдөх 45,лавлагаа хуулбар 56, хувийн хэрэг хаах 11 бүртгэл тус тус бүртгэсэн байна.Үйлчилгээний хураамж 91.2 сая.төгрөг, улсын тэмдэгтийн хураамж 3.5 сая.төгрөг, ҮХЭХҮЭ-ээ худалдсанаас оруулсан татварын орлого 329.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. /2024.12.26-2025.11.10-ны байдлаар/. Үүнээс эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл эрхлэн хөтөлж байгаа 4 сумын бүртгэгч нийт 93 бүртгэлийг бүртгэсэн байна.

Үүнд:

Газар өмчлөх эрхийн гэрчилгээний улсын бүртгэл 1603
- Төрөөс хувьчилсан газрын өмчлөх эрхийг анх удаа бүртгэх 490
- Өмчлөгчийн хүсэлтээр болон гэрээ хэлцлээр бүртгэл салгаснаар шинэ бүртгэл үүсэх 11
- Газар өмчлөх эрх шилжих гэрээний бүртгэл 427
  - Худалдах худалдан авах гэрээ 307
  - Бэлэглэх гэрээ 38
  - Өв залгамжлалаар өмчлөгч өөрчлөгдөх 56
  - Өмчлөгч өөрт ногдох хэсгээ бэлэглэх 23
  - Өмчлөгч өөрт ногдох хэсгээс бэлэглэх-2
  - Шүүхийн шийдвэрээр өмчлөгч өөрчлөгдөх 1
- Барьцааны гэрээ бүртгэх 326
- Барьцааны гэрээ дуусгавар болгох 238

o Үрэгдүүлсэн гэрчилгээ шинээр авах 14
o Гэмтээсэн гэрчилгээ шинэр олгох 1
o Өмчлөгчийн хүсэлтээр бүртгэл салгаснаар хэмжээ өөрчлөгдөх 8
o Эд хөрөнгийн хаяг өөрчлөгдөх 50
o Өмчлөгчийн овог, нэр регистрийн өөрчлөгдөх 1
o Эд хөрөнгийн хэмжээ, үнэ гүйцэтгэл өөрчлөгдөх 27

- Лавлагаа хуулбар олголт 6
  Хувийн хэрэг хаах 2
- Нийт бичигдсэн гэрчилгээний тоо 1020

Газраас бусад үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн гэрчилгээний улсын бүртгэл 1644
- Шинээр баригдсан орон сууц өмчлөх эрхийг анх удаа бүртгэх 145
- Өмчлөгчийн хүсэлтээр болон гэрээ хэлцлээр бүртгэл салгаснаар шинэ бүртгэл үүсэх 3
- Газраас бусад үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийг анх удаа бүртгэх 137
- Өмчлөх эрх шилжих гэрээ 249
  - Худалдах худалдан авах гэрээ 169
  - Бэлэглэх гэрээ 34
  - Өв залгамжлалаар өмчлөгч өөрчлөгдөх 22
  - Шүүхийн шийдвэрээр өмчлөгч өөрчлөгдөх 1
  - Өмчлөгч өөрт ногдох хэсгээс бэлэглэх 8

- o Өмчлөгч өөрт ногдох хэсгээ бэлэглэх 12
- Барьцааны гэрээ бүртгэх 596
- Барьцааны гэрээ дуусгавар болгох 408
- Түрээсийн гэрээ, дуусгавар болгох 1
- o Үрэгдүүлсэн гэрчилгээ шинээр авах 7
- o Өмчлөгчийн хүсэлтээр бүртгэл салгаснаар хэмжээ өөрчлөгдөх 3
- o Эд хөрөнгийн хаяг өөрчлөгдөх 9
- o Эд хөрөнгийн зориулалт өөрчлөгдөх 2
- o Эд хөрөнгийн хэмжээ, үнэ гүйцэтгэл өөрчлөгдөх1 8
- Лавлагаа хуулбар /албан бичиг/ 50
- Хувийн хэрэг хаах 9
- Нийт бичигдсэн гэрчилгээний тоо 565

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын 2023.11.06-ны өдрийн 5/10270 чиглэлийн дагуу эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим системд шинээр баригдсан 5 орон сууцны бүртгэл хийн нотлох баримтуудыг цахимжуулж мэдээг сарын мэдээгээр ЭХЭУБ-ын газарт хүргүүлсэн. Мөн “Онлайн мэдүүлэг” цэсэнд ирсэн барьцааны гэрээ дуусгавар болгох тухай 28 мэдүүлгийг хүлээн авч хугацаанд нь шийдвэрлэсэн. Тус цэсэнд одоогоор “Нотариатын зуучлал”-ын үйлчилгээгээр “Онлайн мэдүүлэг” цэсэнд хүсэлт ирүүлээгүй байна.

Улсын бүртгэлийн цахим системд эх нотлох материалаас зөрүүтэй, алдаатай бүртгэгдсэн зөрчлийг арилгаж, бүртгэл үнэн зөв, нотлох баримтад үндэслэж, хуульд заасан журмын дагуу хөтлөх зарчмыг хангаан улсын бүртгэгч нар бүртгэл хийх бүрдээ урьд эх нотлох баримтуудын дугаарлалтыг хянаж тулган үздэг ба хувийн хэргийн дугаарлалтын алдааг илрүүлж, дараагийн бүртгэл хийх явцдаа УБЕГ-ын хяналтын улсын байцаагчийн 2022 оны 1500 дүгнэлт болон эх нотлох баримтыг үндэслэн бүртгэлд засвар өөрчлөлтийг хийдэг. Энэ онд засвар өөрчлөлтийг 36 удаа хийн бүртгэлийн дэвтэр хөтлөн мэдээг сар бүр батлагдсан маягтын дагуу гарган www.edkhurungu.gov.mn хаягаар илгээж хэвшсэн.

Бүртгэгч нарын үнэт цаасны зарцуулалтын мэдээг сар бүрийн 25-ны өдрөөр дуусгавар болгон хүлээн авч, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим системийн “үнэт цаас ашиглалт” цэсээр үнэт цаасны дугаар, улсын бүртгэлийн дугаар, бүртгэгчийн үнэт цаас зарцуулалтын дэвтрийн бүртгэл зэргийг тулган шалгаж, санхүүгийн ажилтнуудаар хянуулан ажиллаж байна. Тайлант хугацаанд бүртгэгчид газар өмчлөх эрхийн 1020, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн 565 нийт 1585 үнэт цаас зарцуулсан ба 9 үнэт цаасыг техникийн саатал болон бүртгэгчийн буруугаас хүчингүй болгосон байна.

Төрийн болон хууль хяналтын байгууллагад эд хөрөнгөтэй эсэх, үл хөдлөх эд хөрөнгийн дэлгэрэнгүй лавлагаа нийт 292 лавлагааг гарган албан бичгээр хариуг хүргүүлсэн. (Үүнд: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас ирүүлсэн үл хөдлөх эд хөрөнгийн захиран зарцуулах эрхийг түдгэлзүүлэх тогтоолын дагуу 93, үл хөдлөх эд хөрөнгийн захиран зарцуулах эрхийг сэргээх 32, хөрөнгө битүүмжлэх тухай тогтоолын дагуу 2, аймгийн татварын газраас үл хөдлөх эд хөрөнгийн захиран зарцуулах эрхийг сэргээх албан бичгийн дагуу 2 нийт 129 бүртгэлийг эд хөрөнгийн мэдээллийн цахим системийн “албан бичиг” цэсэнд бүртгэн лавлагааг, гэрчилгээний хуулбарын хамт хүргүүлсэн.)

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд 2025 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар Газрын өмчлөх эрхийн анхны бүртгэл 501, газраас бусад үл хөдлөх эд

хөрөнгийн эрхийн анхны бүртгэл 285 шинээр бүртгэгдсэн ба нийт 786 цаасан хувийн хэргийг шинээр үүсгэн архивт хүлээлгэн өглөө.

Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн бүртгэгч, архивч нар Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хувийн хэргийн хяналтын тооллогыг 2025 оны 4 дүгээр сарын 7-14-ны өдрүүдэд хийж гүйцэтгэлээ.





Тооллогод 2025 оны 04 дүгээр сарын 04-ны өдрийн байдлаар архивт байршуулсан газар өмчлөх эрхийн 12711, үл хөдлөх эд хөрөнгийн 4901 нийт 17612 хувийн хэргийг нэг бүрчлэн мэдүүлэг, дугаарын дараалныг шалгаж буцаан байрлууллаа.

Тооллогоор өөр улсын бүртгэлийн хувийн хэрэгт байршуулсан 41 бүртгэлийг улсын

| № | Сумын нэр | Газар өмчлөх эрхийн улсын бүртгэлийн дугаар | Хувийн хэргийн тоо | ГБҮХЭХ өмчлөх эрхийн улсын бүртгэлийн дугаар | Хувийн хэргийн тоо |
|---|---|---|---|---|---|
| 1 | Адаацаг | г0801000001-г0801000256 | 256 | ү0801000001-ү0801000107 | 107 |
| 2 | Дэрэн | г0802000001-г0802000224 | 224 | ү0802000001-ү0802000087 | 87 |
| 3 | Цагаандэлгэр | г0803000001-г0803000152 | 152 | ү0803000001-ү0803000033 | 33 |
| 4 | Говь-угтаал | г0804000001-г0804000299 | 299 | ү0804000001-ү0804000074 | 74 |
| 5 | Баянжаргалан | г0805000001-г0805000242 | 242 | ү0805000001-ү0805000070 | 70 |
| 6 | Өндөршил | г0806000001-г0806000406 | 406 | ү0806000001-ү0806000112 | 112 |
| 7 | Гурвансайхан | г0807000001-г0807000265 | 265 | ү0807000001-ү0807000130 | 130 |
| 8 | Өлзийт | г0808000001-г0808000115 | 115 | ү0808000001-ү0808000058 | 58 |
| 9 | Луус | г0809000001-г0809000218 | 218 | ү0809000001-ү0809000038 | 38 |
| 10 | Хулд | г0810000001-г0810000241 | 241 | ү0810000001-ү0810000091 | 91 |
| 11 | Дэлгэрхангай | г0811000001-г0811000345 | 345 | ү0811000001-ү0811000093 | 93 |
| 12 | Сайхан-овоо | г0812000001-г0813000342 | 342 | ү0812000001-ү0812000109 | 109 |
| 13 | Эрдэнэдалай | г0813000001-г0813001501 | 1501 | ү0813000001-ү0813000241 | 241 |
| 14 | Сайнцагаан | г0814000001- г0814007907 | 7907 | ү0814000001- ү0814003602 | 3602 |
| 15 | Дэлгэрцогт | г0815000001-г0815000198 | 198 | ү0815000001-ү0815000056 | 56 |
| 16 | | Нийт | 12711 | | 4901 |

бүртгэлийн дугаар бүхий хувийн хэрэгт байршуулж, тусгаарласан 48 бүртгэлийг  устгалаа.

2025.09.04-ны өдөр Говь-Угтаал сумын Хараат хэмээх газарт орших “Шанжин орд” ХХК-ны Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлт гаргасан 10 үл хөдлөх эд хөрөнгийг, хяналтын улсын байцаагч Д.Нямсүрэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн дарга Л.Мөнхсарнай нар газар дээр нь очиж обьектийн үзлэг хийж, зөвлөгөө өглөө.









**ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР**

Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан нэмэлт өөрчлөлт оруулсан: ххк 88, Хоршоо 39, ХЗХ 8, Улсын төсөв үйлдвэрийн газар 10, төрийн байгууллага 6, ТББ 9, ҮЭХ 2, Боловсрол соёлын сургалтын байгууллага 43. ОНӨААҮГ 4 бүртгэсэн,ТӨААТҮг 1, Иргэн, хуулийн этгээдэд лавлагаа олгосон 64, Салбар төлөөлөгчийн газар бүртгэсэн 6, нийт 220 хуулийн этгээдийн мэдээлэлд нэмэлт өөрчлөлт оруулан 64 иргэн, хуулийн этгээдэд лавлагаа олгосон.

Шинээр 149 хуулийн этгээд байгуулсан. Үүнээс: ххк 61, хоршоо 57,Төрийн бус байгууллага 11 , ОНӨААТҮГ 1, ҮЭБ 1, нөхөрлөл 7 бүртгэгдсэн байна.

Дахин гэрчилгээ олгосон 72 , ,шилжилт хөдөлгөөн хийсэн 6 , нийт 433 бүртгэл хийж архивд 2115 хувийн хэрэг байршиж байна

“Тамга тэмдэг баталгааны тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих лавлагаа олгох журам”-д зааснаар Хяналтын дугаар олгосон шинээр 150 , дахин олгосон 62, хураан авсан 76 тамга, тэмдэг архивд шилжүүлсэн. Хуулийн этгээдийн бүртгэлээс орон нутгийн орлогод:19193600 төгрөгийн орлого төвлөрүүлсэн.

Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хуулийн 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр боловсролын сургалтын байгууллага сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжил болон техникийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын 39 сургууль, цэцэрлэгийн хэлбэрийг өөрчлөн хуулийн хэрэгжилтийг хангасан.

Хуулийн этгээдийн оноосон нэрийг e-business.mn хүлээн авч татгалзсан 1407 , зөвшөөрсөн 242 , баталсан 25 , цуцалсан 157 нийт 1407 оноосон нэрийн бүртгэлийг баталгаажуулсан.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 26 дугаар зүйлийн 26. Хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд санхүүгийн тайлангаа найм ба түүнээс дээш улирал дараалан гаргаагүй, харилцагч санхүүгийн байгууллагад илгээж баталгаажуулаагүй хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хасах талаарх 122 хуулийн этгээдийн жагсаалтаар ирүүлсэн. 8 хуулийн этгээдэд мэдэгдэж хуулийн этгээд тус бүрээр холбогдох газартай тулгалт хийж эхлээд байна.

Дундговь аймгийн татварын хэлтэстэй хамтран 2009 оноос хойш үйл ажиллагаа явуулаагүй татан буугдсан хуулийн этгээдийн тулгалт хийж 369 хуулийн этгээдээс 5 хуулийн этгээдийг мэдээллийн сангаас хассан.

Дундговь аймгийн Цагдаагийн газрын 3, ШШГ-газрын 2.Татварын газрын 2 нийт 7 албан бичгийг хүлээн авч хугацаанд хариу хүргүүлсэн.

Дэлгэрхангай суманд иргэний бүртгэлийн тасгийн дарга Б.Сайхантуяатай хамтран 2025 оны 5 сарын 28-ны өдөр ”Малчдын зөвлөгөөн” 4жи төхөөрөмж ашиглан шинээр 1 ххк, Хоршооны нэмэлт өөрчлөлт 1, 3 иргэнд зөвлөгөө өгч ажилласан.

“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв”-ийн сэтгэл зүйч Г.Нямпагмаар бүртгэлийн үйлчилгээний анхлан шатны танилцуулах дохионы хэлээр мэдээлэл бэлтгэн real бэлтгэн цахим сүлжээнд цацахаар бичлэг, дүрсийг бэлтгээд байна..

Өлзийт сумын буянт багийн нийтийн хуралд эд хөрөнгө, иргэний бүртгэлийн бүртгэгч нартай хамтран бүртгэлийн үйлчилээг сурталчилан зөвлөгөө өгч 5 иргэнээс цахимаар сэтгэл ханамжийн судалгааг авч цахим байдлаар рийл бичлэг хийж нийтэд түгээсээр 3.5 хүний хандалт авсан. https://www.facebook.com/reel/2955398404665624






Хамтран ажиллагч аймгийн татварын хэлтэсээс зохион байгуулсан “Татвар төлөгчийн өдөр” өдөрлөгт хуулийн этгээдийн бүртгэлээр оролцож 3 хуулийн этгээдэд зөвлөгөө өгч “АХА” хөгжөөнт тэмцээнд нярав Ц.Уртнасангийн хамт амжилттай оролцсон.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас ирүүлсэн 2025 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 4/5158 дугаартай чиглэлийн дагуу 2025 оны 4 дүгээр сарын 24-ны өдөр байгууллагын шуурхай хурал дээр чиглэлийг танилцуулсан ба 4 дүгээр сарын 25-ны сумдын 12 бүртгэгч нарт “Өрсөлдөөний тухай холбогдох заалтууд Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн холбогдох заалтууд Хуулийн этгээдийн оноосон нэр өгөхөд анхаарах зүйлүүд, “Үнэт цаасны компани” гэсэн дэлгэрэнгүй тэмдэглэгээтэй , эсхүл “ҮЦК” гэсэн товчилсон тэмдэглэгээтэй бүртгэхэд анхаарч ажиллах талаарх мэдээллийг цахимаар хүргэлээ.

Хэлтсийн даргын 2025 оны 5 сарын 13-ны өдрийн 85 жилийн ойн баярыг угтсан ажлын хүрээнд Хяналтын улсын байцаагч Д.Нямсүрэнгээр ахлуулсан 2-р багийн гишүүдийн хамтаар “happy family day” арга хэмжээг зохион байгуулан “гэр бүлийн аз жаргал” сэдэвт бүтээл хийх уралдаан зохион байгуулж, шилдэг гэр бүлээр архивч Э.Мөнхсумъяа, мэдээлэл технологийн ажилтан Г.Алтан-Од нарын гэр бүл шалгарч гэр бүлийн “алтан од” цом, дурсгалын зүйлээр шагнууллаа.

Эмэгтэйчүүдийн эрх, жендерийн тэгш байдал, эмэгтэйчүүдийг алагчилах явдлаас урьдчилан сэргийлэх талаар боловсрол олгох, “Бусдыг байгаагаар нь хүлээж авах” сэдвээр сургалтыг хэлтсийн албан хаагчдад зохион байгуулан

Мөн төрийн албаны ёс зүйн тухай хуулиар 30 асуулт бүхий үгийн сүлжээ бөглүүлэн албан хаагчид хууль, эрх зүйн мэдлэгээ сорьж нэгэн өглөөг халуун кофе, дулаан уур амьсгалаар ажлаа эхлүүллээ.

Хуулийн этгээдийн бүртгэлийн эрхтэй Дэрэн, Сайхан-Овоо, Говь Угтаал сумын бүртгэгч нарт тухай бүрд нь чиглэл өгч, бусад сумын улсын бүртгэгчээр дамжуулан хуулийн этгээдийн бүртгэлийн анхан шатны нотлох баримтыг шалгуулан авч мэдлэг, мэдээллээр ханган ажиллаж байна. Дэлгэрхангай 1, Сайхан-Овоо 1, Дэрэн 3, Говь-Угтаал 2, мэдээлэлд өөрчлөлт оруулсан 8, 14 бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн байна.

## СУРГАЛТЫН СУРТАЛЧИЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Улсын бүртгэлийн хэмжээнд дагаж мөрдөж байгаа хууль, дүрэм, журмыг сурталчилах талаар:

Улсын бүртгэлийн ерөнхий газрын www.burtgel.gov.mn, хэлтсийн www.dundgovi.burtgel.gov.mn сайтууд болон facebook хаягаар цацагдаж байгаа мэдээ, мэдээллүүд, видео, контентуудыг цаг тухай бүрд нь олон нийтэд түгээн ажиллаж байна. Сумдын facebook группүүдэд зөөврийн тоног төхөөрөмжөөр бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх тухай зурагт баннер хийж түгээж байна.

Улсын бүртгэлийн хөдөлгөөнт үйлчилгээ 4G төхөөрөмжөөр 5 сарын 1-нд Хуульчдын холбооноос жил бүр зохион байгуулдаг “Пробоно” өдөрлөгт хамтран оролцож 20, 5 дугаар сарын 14,15,19,21 6 дугаар сарын 2-ны өдрүүдэд аймгийн Засаг дарга сумдад ажиллан “Хөдөөгийн сэргэлт-шинэ Дундговь” иргэдтэй хийсэн уулзалтын үеэр 15 сумын малчдын өдөрлөгт давхардсан тоогоор нийт 1200 орчим иргэн, хуулийн этгээдэд Хуулийн

этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн зөвлөгөө, мэдээлэл хүргэн, бүртгэл хийн, гарын авлага тараалаа.














11 дүгээр сарын 6-ны өдөр аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын ажлын байр, “Мандал худалдааны төв”-ийн 1 давхарт 4жи төхөөрөмжөөр 43 иргэнд үйлчилгээ үзүүлэн, qr кодтой цахим гарын авлагыг 146 иргэнд тараан, мэдээлэл хүргэж,цахим мэдээллийг түгээлээ..




ГАЗРЫН ХАРИЛЦАА
WWW.EGAZAR.GOV.MN
Л.МӨНХСАРНАЙ
Full









Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас ирүүлсэн 2025 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 4/5158 дугаартай чиглэлийн дагуу 2025 оны 4 дүгээр сарын 24-ны өдөр байгууллагын шуурхай хурал дээр чиглэлийг танилцуулсан ба 4 дүгээр сарын 25-ны сумдын 12 бүртгэгчид мэдээллийг цахимаар хүргэлээ. Цахим мэдээллээр:

Хуулийн этгээдийн улсын бүртгэгч Б.Одонтунгалаг:

- Хуулийн этгээд байгуулах, удирдах албан тушаалтан өөрчлөх, хуулийн этгээдийн эрхийг шилжүүлэх болон бусад ямар нэгэн байдлаар холбоотой баримт бичиг, хувь хүний мэдээллийг хуулийн хүрээнд судлан шинжилж бүртгэх

- Иргэн, хуулийн этгээдээс гаргасан өргөдөл хүсэлт түүнд хавсаргасан холбогдох баримт бичиг хуурамчаар үйлдэгдсэн буюу ямар нэгэн байдлаар гэмт хэргийн шинжтэй байгаа тохиолдолд даруй цагдаагийн байгууллагад мэдэгдэж хэвших

- Өрсөлдөөний тухай хуулийн холбогдох заалтууд

- Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн холбогдох заалтууд

- Хуулийн этгээдийн оноосон нэр өгөхөд анхаарах зүйлүүд, “Үнэт цаасны компани” гэсэн дэлгэрэнгүй тэмдэглэгээтэй , эсхүл “ҮЦК” гэсэн товчилсон тэмдэглэгээтэй бүртгэхэд анхаарч ажиллах

Хяналтын улсын байцаагч Д.Нямсүрэн:

- Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны А/1715 дугаартай тушаалын хавсралтаар батлагдсан “Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн санд ажиллах журам”-ыг танилцуулж өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг

- Хуулийн этгээдийн болон эрх бүхий этгээдийн өмнөөс улсын бүртгэлд бүртгүүлэхээр хүсэлт гаргаж байгаа тохиолдолд түүнд хавсаргасан холбогдох бичиг баримтыг хуурамчаар үйлдсэн эсхүл ямар нэгэн байдлаар гэмт хэргийн шинжийг агуулсан бол иргэний талаарх мэдээллийг цагдаагийн байгууллагад нэн даруй мэдэгдэх

- Өөрийн эрхлэх үйл ажиллагаанд хамааралгүй асуудлаар улсын бүртгэлийн мэдээллийн санд нэвтрэх, лог үүсгэхгүй байх талаар анхааруулж үүрэг даалгавар өглөө.

Хэлтсийн албан хаагч эмэгтэйчүүдэд өөрийгөө хөгжүүлэх, эмэгтэй энергээ сэргээх, харилцаандаа юуг анхаарвал зохих талаар чөлөөт ярилцлагыг удирдлагын зүгээс дресс кодтой зохион байгуулж урам зоригийг сэргээсэн үйл ажиллагаа зохион байгууллаа. Өрх гэр, ажлын байр, цаашлаад орон нутаг нийгэмдээ үлгэрлэн манлайлах талаар ярилцаж өнгөрүүллээ.



## 3-РТ МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, МТЕХНОЛОГИЙН ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД:

Нээлттэй мэдээллийн ил тод байдлын 68 шалгуур үзүүлэлтийн дагуу shilen.gov.mn сайтад 3-р улирлын тайланг хугацаанд нь 68 шалгуур үзүүлэлтийн дагуу мэдээллийг байршуулсан. Үүнд: 68 шалгуур үзүүлэлт нь 4 чиглэлд хуваагдан 93%-тай үнэлэгдсэн.

1. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал-96%

2. Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал-97%

3. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал-97%

4. Үзүүлж байгаа үйлчилгээний талаар дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байдал-98% тус бүрийн үнэлгээ.




Нээлттэй мэдээлийн ил тодын 68 шалгуур үзүүлэлтийн дагуу www.gov.mn болон shilen.gov.mn сайтад 4-р улирлын тайланг байршуулж байна. 2025 оны 11-р сарын 10-ны байдлаар УБЕГазар, бүртгэлийн хууль тогтоомж, үйл ажиллагаатай холбоотой мэдээ 125, АТГ-9, АЗДТГ-244, emongolia-50, -ХЗДХЯ-39, Цахим хөгжил, инновац холбооны яам-20, бусад холбогдох байгууллага болон хэлтсийн үйл ажиллагаатай холбоотой 92 мэдээ бэлтгэн хэлтсийн веб сайт, пэйж хуудсанд байршуулж нийт 579 мэдээг түгээсэн байна. Улсын бүртгэлийн үйлчилгээг цахим машинаар /Киоск/ үзүүлэх үйлчилгээг сурталчлах

зорилгоор Баянжаргалан, Хулд, Говь-Угтаал, Өлзийт 4 суманд ОНТС-ээр цахим машиныг /киоск/ авч иргэдэд цахимаар үйлчилгээ үзүүлэх боломжыг нэмэгдүүллээ. Тус хэлтсийн 5 цахим машинаар /Киоск/ 2714 лавлагаа үйлчилгээ, 1327 тоон гарын үсэг олгогдсон байна.




Сүлжээний зөөврийн 4g төхөөрөмж ашиглан ШШГГ, Баянжаргалан, Дэрэн, Дэлгэрцогт, Дэлгэрхангай, Цагаандэлгэр, Говь-Угтаал, Гурвансайхан, Луус, Өндөршил, Луус, Адаацаг, Өлзийт, Эрдэнэдалай, Сайхан-Овоо, Сайнцагаан суманд Аймгийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 09-ны өдрийн А/407 тоот захирамжын нэгдүгээр хавсралтад дурьдсан хуваарийн дагуу аймгийн Засаг даргын сумдын иргэдтэй хийх “Хөдөөгийн сэргэлт-шинэ Дундговь” уулзалтын үеэр нийт 28 удаа ашиглан бүртгэлийн үйлчилгээг сурталчилан ажиллалаа.






Хэлтсийн хэмжээнд ашиглагдаж байгаа цахим мэдээллийн сан, мэдээллийн нэгдсэн сүлжээ, тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаа, мэдээллийн санд нэвтрэх аюулгүй ажиллагааны журмын хэрэгжилтийг улирал бүр компьютерийн нууц үгийг солин, тоног төхөөрөмжийн бүртгэлийн 28 хуудас бөглүүлж, 3 үйлдэлт hp laserjet 428 принтерийн 30 чип сольж, цаг агаарын байдлаас шалтгаалан Univision-ийн шилэн кабель тасарч, хариуцсан инженерийг дуудан засвар үйлчилгээ хийлгэн сүлжээний хэвийн ажиллагааг ханган ажиллалаа. Нэг цэгийн үйлчилгээний сүлжээний 2 свичийг шинэчлэн, сүлжээний болон камерийн ил утсыг далдлан, архивын серверийн өрөөнд камер суурилуулж сүлжээ болон тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна. Хэлтсийн

хэмжээнд нэг цэгийн үйлчилгээний танхим, архивын серверийн өрөө, 2 давхрын серверийн өрөө тус бүрт камер, тог баригч суурилуулсан.












УБЕГ-ын МТГ-аас мэдээлэл технологийн албан хаагчдын мэдлэг дээшлүүлэх сургалтанд А,В конвертер-1ш, сүлжээний толгой, лангын утас, багажны комыг өгч тоног төхөөрөмж, бусад хэрэгслийн нөөцийг бүрдүүлж өгсөн. 2025.10.23-ны өдөр Дундговь аймгийн МХСүлжээ ХХК-ны инженер Батболдтой хамтран Аймгийн ЗДТГ-ын хэлтсийн архиваас шилэн кабель Сайнцагаан сумруу татан МТГ-аас ирсэн шинэ А,В конверторыг суурилуулж, кабелийн утсийг далдлагчаар далдаж, Сайнцагаан сумын улсын бүртгэгч Ш.Чулууны техник, тоног төхөөрөмж болон сүлжээний аюулгүй, бүрэн бүтэн байдлыг ханган ажиллалаа. УБЕГ-аас ирсэн firewall switch-ийг МТГ-ийн инженер Анхбаяртай хамтран тохиргоо хийлгэж серверийн өрөөнд шинэчлэн солилоо. Серверийн өрөөнд байрлах интернэтийн switch-ээс нэг цэгийн үйлчилгээний танхимруу шинэ switch холбов. Улсын бүртгэлийн ерөнхий газрын болон аймаг орон нутгаас зохион байгуулсан нийт 10 сургалтанд хамрагдлаа.

1. УБЕГ-ын МТГ-аас мэдээллийн технологийн албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтанд хамрагдан, ярилцлага хэлэлцүүлэг хийлээ.




2. Ажилтан албан хаагчдын бие бялдрыг хөгжүүлэх “Спорт-2025” сургалтанд Төвийн бүсээрээ Гар бөмбөг мөнгөн медаль, дартас тусгай байр нийлбэр дүнгээр II-р байр эзэллээ.





3. Хүний эрх үүрэг ба жендерийн эрх тэгш байдлын талаарх сургалтанд багаар ажиллаж хэлэлцүүлэг хийлээ.





4. АЗДТГ-аас зохион байгуулсан нийтийн мэдээллийн ил тод хариуцсан албан хаагчдад www.gov.mn хэрхэн сайтаа ашиглах, хөгжүүлэх сургалтанд хамрагдсан.

5. Залуучуудын бүсчилсэн хөгжлийн хэлэлцүүлэг болж өөрийн санал бодлоо бусадтай хуваалцан туршлага судаллаа.




6. “DATA ANALYSIS" АЗДТГ-ын сургалтанд хамрагдаж сертификат авч амжилттай хамрагдлаа.






7. Улсын бүртгэлийн байгууллага үүсч хөгжсөний түүхт 85 жилийн ойг тохиолдуулан “Миний гэр бүл миний толь” сургалтанд хамрагдаж шилдэг гэр бүлээр шалгарч “МИНИЙ ГЭР БҮЛ-МИНИЙ ТОЛЬ” цомыг гардан авлаа.









.

8. Хууль зүй, дотоод хэргийн сайдын санаачилгаар хэрэгжиж буй “Хамгийн чухал нь эрүүл мэнд” зорилтот хөтөлбөрийн хүрээнд эрүүл мэндийн үзлэгт гэр бүлийн хамт хамрагдсан.





9. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд шинээр мод тарьж, ургуулах 50 мод тарихаас гэр бүлийн хамт 10 мод тарилаа.





10. УБЕГ-ын brand book-ыг тус хэлтэст нэвтрүүлж 2 ханын хаяг , 3 мэдээллийн самбар, хаалганы хаягыг солин албан хаагчдад зангиа бэлэглэлээ.




































## 4-РТ ДОТООДЫН ХЯНАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР

Хяналтын улсын байцаагч нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилтын хүрээнд 26 арга хэмжээ төлөвлөснөөс 26 арга хэмжээг 100 хувьтай хэрэгжүүлж ажиллалаа.

Тайлант хугацаанд төлөвлөгөөт хяналт шалгалт 8, гэнэтийн болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт 2, Өргөдөл, санал, гомдлын мөрөөр хийсэн шалгалт 1 байна. Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 2111 бүртгэлд хийснээс иргэний улсын бүртгэлийн 999, ЭХЭУБ-ын 957, хуулийн этгээдийн 140, архивын чиглэлээр 15 байна. Үүнээс иргэний улсын бүртгэлийн 50, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 92, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 16, архивын үйл ажиллагааны 2 алдаа зөрчил илэрсэн байна. Илэрсэн алдаа зөрчлийг ХША-1 маягтаар тэмдэглэл хөтөлж, албан хаагчдад зөрчлийн тэмдэглэлээр хүргүүлж, засагдах боломжтой алдаа, зөрчлийг тухай бүр засч, дүгнэлтээр засах алдаа зөрчлийг дүгнэлтээр засч ажиллалаа. Хяналтын улсын байцаагчийн 32 дүгнэлт, 1 мэдэгдэл үйлдэж хяналт шалгалт, зөрчлийн нэгдсэн санд цахимжуулллаа. Үүнд: иргэний улсын бүртгэлийн 7, хуулийн этгээдийн 3, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 22 тус тус дүгнэлт байна.


Цагаан-Овоо багийн 16, 25, 45 насны хүмүүс

2/7

| Д/д | Ургийн овог | Овог | Нэр | нас | Хүйс | Регистр |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | бургэд | цэрэнсамба | баярмаа | 45 | эм | эп79020803 |
| 2 | сартуул | сумъяадорж | тунгалагтуяа | 45 | эм | эю79120900 |
| 3 | боржигон | Хишигдэлгэр | Тогтохбаяр | 16 | эр | УП08262436 |
| 4 | нэхий гучин | төмөрхуяг | эрдэнэцэцэг | 45 | эм | эж79122602 |
| 5 | тэгрэг | хатантөмөр | мөнгөншагай | 16 | эр | эп08211514 |
| 6 | боржигон | батболд | номиндалай | 16 | эр | эп08240917 |
| 7 | мангуд | отгонбаяр | бадамлянхуа | 25 | эм | эп99070809 |
| 8 | баваа | чулуунсүх | хүслэн | 16 | эр | эп08300116 |
| 9 | тантав | гантулга | цэцгээ | 25 | эм | ВС99061001 |
| 10 | баяжих | гансүх | ундармаа | 25 | эм | эп99030801 |
| 11 | халтай | ганболд | лхагвасүрэн | 45 | эм | эм79101403 |
| 12 | залан | энхтайван | удвал | 25 | эм | эп99061508 |
| 13 | Баяжих | Сугардорж | Есөнхишиг | 25 | эм | УХ99012408 |
| 14 | тэгрэг | болдбаатар | дамдинцэрэн | 25 | эр | ЗП99082118 |
| 15 | тэгрэг | болдбаатар | мичидмаа | 16 | эм | эп08230806 |
| 16 | олохнууд | эрдэнэбаяр | алтанхуяг | 16 | эр | эп08310512 |
| 17 | тулгат | починсамба | бямбасүрэн | 45 | эм | эп79021003 |
| 18 | огнууд | хүүбаатар | чойндмаа | 16 | эм | эп08301701 |
| 19 | бургад | эрэндум | гансүрэн | 45 | эм | эп79050600 |
| 20 | бургад | цэрэночир | батзориг | 45 | эр | эп79012831 |
| 21 | жаргалант | жанцан | эрдэнэцэцэг | 45 | эм | эп79080203 |
| 22 | боржигин | магмардорж | ганбаяр | 25 | эр | эп99102817 |
| 23 | баваа | батмөнх | цэнгэлмаа | 16 | эм | эп08260603 |
| 24 | хөхдүгант | батсүх | дуламрагчаа | 25 | эм | ЗП99072309 |
| 25 | тайж | даш | батболд | 45 | эр | эп79010219 |
| 26 | олдохнууд | ганболд | болормаа | 45 | эм | эа79091408 |
| 27 | түмэд | чулуунбаатар | гомбосүрэн | 45 | эр | эп79102613 |
| 28 | жаалайн е | тогтохбаяр | мөнхоргил | 25 | эр | эл99011815 |
| 29 | залан | эрдэнэ-очир | энхболд | 45 | эр | эп79042616 |
| 30 | зурхайч | ганбаатар | намуунбайгал | 16 | эм | эп08273001 |
| 31 | онгиуд | аюуш | бямбасүрэн | 45 | эм | эа79092201 |
| 32 | гучин тэгр | долгормаа | хонгорзул | 16 | эм | эп08291928 |
| 33 | гучин тэгр | долгорсүрэн | баяржавхлан | 16 | эр | эп08212814 |
| 34 | олхнууд | тэрбат | оюунчимэг | 45 | эм | эп79051005 |
| 35 | дуут | дугаржамц | энхбаатар | 45 | эр | эп79112311 |
| 36 | дуут | энхбаатар | түвшинтөгс | 16 | эр | эп08300914 |
| 37 | тайж | сарантуяа | эрдэнэбат | 16 | эр | эп08320412 |
| 38 | рашаант | Энхсайхан | Жамбалсүрэн | 16 | эр | эп08310415 |

2025 онд хяналтын улсын байцаагчид төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем https://erp.e-mongolia.mn порталаар нийт 24

албан бичиг, 6 өргөдөл ирүүлсэн бөгөөд хуулийн хугацаанд боловсруулж шийдвэрлэсэн. Өргөдөл шийдвэрлэлтийн дундаж хугацаа 4 хоног байна.

Дундговь аймгийн хэмжээнд 2025 онд 16,25,45 нас хүрэх иргэдэд зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хуульд заасан хугацаанд улсын бүртгэлд бүртгүүлээгүй тохиолдолд гарч болох эрсдэл, торгууль шийтгэлийн талаар цахим контент хэлбэрээр сурталчилгаа хийх, албан байгууллага, сургуулиудад мэдээлэл хийх гэх мэт олон ажлыг зохион байгуулж ажиллалаа. Тайлант хугацаанд нийт 63 зөрчил хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэнээс зөрчлийн тухай хуулийн 15.24.1-д заасан зөрчил үйлдсэн-58, 15.24.2-д заасан зөрчил үйлдсэн -2, 15.24.4-д заасан зөрчил үйлдсэн-3 байна.

Зөрчлийн тухай хуулийн 15.24.4-д заасан зөрчил иргэний улсын бүртгэлийн талаар тогтоосон журам зөрчсөн буюу ихэвчлэн иргэний үнэмлэх үрэгдүүлсэн зөрчлийг E-mongolia.mn цахим үйлчилгээний нэгдсэн порталаар иргэний цахим үнэмлэхийг захиалуулж байна. Сумдын улсын бүртгэгч нар тухайн онд 16 насанд хүрэх, хугацаа сунгах иргэдийн нэрсийг багийн дарга нараас гаргуулан авч, нэг бүрчлэн утсаар холбогдож зөвлөгөө, мэдээлэл, иргэний үнэмлэхийн хугацаа сунгах сануулга өгч ажилладаг бөгөөд Дундговь аймгийн төвийн сумаас бусад сумдаас иргэний үнэмлэхийн хугацааны торгууль төлөхөөр ирэх иргэдийн тоо буурсан бөгөөд иргэдэд чирэгдэлгүй, цаашдаад бусад эрсдлээс урьдчилан сэргийлж байгаа давуу талтай юм.

Зөрчлийг бууруулах зорилгоор иргэдэд видео шторк явуулах, facebook хуудсаар мэдээлэл түгээх, ерөнхий боловсролын сургуулиудад танилцуулга, мэдээлэл хүргүүлэх зэрэг ажлуудыг хийлээ. Мөн түүнчлэн 15 сумдын улсын бүртгэгч нараас 2025 онд 16, 25, 45 насанд хүрч иргэний үнэмлэх захиалах иргэдийн судалгааг авч, иргэн бүртэй утсаар, болон биеэр холбогдож төрсөн өдрөөс хойш 30 хоногийн дотор иргэний үнэмлэхийн сунгалтаа хийлгэх ёстойг сануулж ажиллах үүргийг сумдын бүртгэгч нарт өгсөнөөр төвийн сум буюу Сайнцагаан сумаас бусад 14 сумдаас хууль, журам зөрчсөн зөрилтэй бүртгэл бүртгэгдэхгүй болсон. Уг ажлыг хийснээр зөрчлийн тухай хуулиар торгуулах иргэдийн тоо буурч байгаа давуу талтай юм. 2025 онд нийт 36 иргэнд иргэний үнэмлэх захиалахад заавар, зөвлөмж өгч ажиллалаа. Мөн тоогоор зөрчлийн хэрэг хялбаргуулсан журмаар хянан шийдвэрлэх тоо буурсан давуу талтай.






16 насанд хүрч иргэний үнэмлэх анх

удаа авах хүүхдүүдэд зөрчлийн тухай хуулийг таниулах, улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааг сурталчлах зорилгоор  Цэгц илэг сургуулийн 10А, 10Б аниудыг 2025 оны 05 сарын 06-ны өдөр хэлтсийн байранд урьж “16 нас”  сэдэвт өдөрлөгийг зохион байгууллаа. Өдөрлөгөөр 2 ангийн 72 сурагчдад улсын бүртгэлийн ерөнхий хууль, иргэний улсын бүртгэлийн тухай хууль, зөрчлийн тухай хуулийн  талаар товч мэдээлэл өгч, байгууллагын үйл ажиллагаатай танилцуулж, 16 нас хүрсэн 6 сурагчийн иргэний үнэмлэхийг захиалуулж, цахим киоск машинаас иргэний үнэмлэхийн лавлагаа хэвлэх гэх мэт тухайн насны хүүхдүүдийн авч болох бүртгэлийг сурталчиллаа.

“улсын бүртгэл миний нүдээр” reel бичлэгийн уралдаан зарлаж хүүхдүүд өөрсдийн нүдээр улсын бүртгэлийн байгууллага ямар ажил хийдэг талаар бичлэг хийж цахим орчинд түгээсэн. 2 ангийн бичлэг хандалтын тоогоороо 59.200 иргэнд **хүрсэн байна. Хандалтаараа түрүүлсэн 10Б ангийг дурсгалын зүйлээр шагнаж урамшуулсан.**

https://dundgovi.burtgel.gov.mn/post/67651?fbclid=IwY2xjawKZMIhleHRuA2FlbQIxMABicmlkETFpVHJtNDNLR0QzVndqa3RaA








R7uN5s6aUcrElRbAPA5T1slIw5i0WQbVtmPiMjElTu16pmvonLAHRj4tJ4A2Q_aem_zgALTsEHrJveQ64pPkV39A












**Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр хийсэн хяналт, шалгалт**



2025 оны 03 дугаар сард төрсний бүртгэл-262, гэрлэсний бүртгэл-53,

2025 оны 04 дүгээр сард шилжилт хөдөлгөөний бүртгэл-386

2025 оны 05 дугаар сард нас барсны-83, ОНӨ бүртгэл-10, эцэг тогтоолын бүртгэл-5

2025 оны 06 дугаар сард гэрлэлт цуцлалт-26, үрчлэлт-8

бүртгэлд тус тус хяналт шалгалт хийж улсын бүртгэгч нарт нийтлэг гарч буй алдаа зөрчил, цаашид анхаарах асуудлын талаар Иргэний улсын бүртгэлийн тасгийн даргад танилцуулж, тасгийн даргатай хамтран 2025 оны 03 дугаар сарын 24-ны өдөр сумдын бүртгэгч нарт цахим сургалт зохион

байгуулж, улсын бүртгэлийн дотоод гурпп /сумын бүртгэл 2025/ чатад тухай бүр чиглэл зөвлөмжийг хүргэж ажиллалаа.

УБЕГазрын 2025 оны 06 сарын 25 -ны өдрийн 1/8305 тоот зөвлөмжийн хүрээнд иргэний улсын бүртгэлийн тасгаас улсын бүртгэгчдэд чиглэл өгөх сургалтыг цахимаар зохион байгууллаа. Сургалтаар гэрлэлт дуусгавар болсны бүртгэл хөтлөхөд анхаарах асуудлаар улсын ахлах бүртгэгч Б. Сайхантуяа, "Шүүхийн шийдвэрийн хуулийн хүчин төгөлдөр хугацааг анхаарах асуудлаар хяналтын улсын байцаагч Д. Нямсүрэн нар мэдээлэл өглөө. Гэр бүлийн тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Иргэний улсын бүртгэл хөтлөх журам зэрэг холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллахаас гадна иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сан, архивын санд бүртгэл хийхээс өмнө заавал шалгаж нягтлах, өргөдлийн шаардлагыг хангуулж дэлгэрэнгүй бичүүлж байх, шүүхийн шийдвэрийн хүчин төгөлдөр хугацаа гэдгийг хэрхэн ойлгох, итгэмжлэл болон шүүхийн шийдвэрийн нэхэмжлэлийн шаардлага, тогтоох хэсгийн утга, агуулгыг бүрэн гүйцэт уншиж танилцан үнэн зөв бүртгэл хөтлөхөд анхаарч ажиллах талаар үүрэг даалгавар, мэдээлэл арга зүйн зөвлөмж өглөө. Сургалтад нийт 12 албан хаагч хамрагдлаа.

**ЭХЭУБ-ийн чиглэлээр хийсэн хяналт, шалгалт**

2025 оны 1,2,3, 4 дүгээр сард төрөөс хувьчилсан газрын анхны бүртгэл 298, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн анхны бүртгэл 123, шинээр баригдсан орон сууцны бүртгэл 145

2025 оны 5,6 дугаар сард худалдах, худалдан авах гэрээ 103, бэлэглэх гэрээ 86, өв залгамжлалаар өмчлөгч өөрчлөгдөх-78

2025 оны 8,9,10 сард барьцаат зээлийн гэрээ дуусгавар болох, барьцаат зээлийн гэрээ-124 бүртгэлд тус тус хяналт шалгалт хийж илэрсэн алдаа зөрчлийг ХША-1 маягтаар тэмдэглэл хөтөлж, албан хаагчдад зөрчлийн тэмдэглэлээр хүргүүлж, засагдах боломжтой алдаа, зөрчлийг тухай бүр засч, дүгнэлтээр засах алдаа зөрчлийг дүгнэлтээр засч ажиллалаа.



Мөн шинээр барьж ашиглалтад оруулж буй орон сууцны 5 бүртгэлд анхан шатны нотлох баримтын бүрдүүлэлтэд хяналт хийж, зөвлөн тусалж бүрдүүлбэрыг бүрэн бүрдүүлж эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим системд цахимжуулж Ж дугаар олгууллаа.

2025.09.04-ны өдөр Говь-Угтаал сумын Хараат хэмээх газарт орших “Шанжин орд” ХХК-ны Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлт гаргасан 10 үл хөдлөх эд хөрөнгийг хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн дарга Л.Мөнхсарнайтай газар дээр нь очиж обьектийн үзлэг хийж, зөвлөгөө өглөө.

Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн бүртгэгч, архивч нар Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хувийн хэргийн **хяналтын** тооллогыг 2025 оны 4 дүгээр сарын 7-14-ны өдрүүдэд хийсэн бөгөөд илтгэх хуудасаар хяналтын улсын байцаагчид тайланг ирүүлсэн.

Тооллогод 2025 оны 04 дүгээр сарын 04-ны өдрийн байдлаар архивт байршуулсан газар өмчлөх эрхийн 12711, үл хөдлөх эд хөрөнгийн 4901 нийт 17612 хувийн хэргийг нэг бүрчлэн мэдүүлэг, дугаарын дарааллыг шалгаж буцаан байрлуулж, өөр улсын бүртгэлийн хувийн хэрэгт байршуулсан 41 бүртгэлийг улсын бүртгэлийн дугаар бүхий хувийн хэрэгт байршуулж, тусгаарласан 48 бүртгэлийг устгасан байна. Тайланд ирүүлсэн алдаа зөрчил, дутуу нотлох баримт, дутсан хувийн хэргийг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн EPRS системд шалгаж 6 бүртгэлийг дүгнэлтээр засварлалаа.



**Хуулийн этгээдийн чиглэлээр хийсэн хяналт, шалгалт**

2025 оны 1-10 сард шинээр байгуулагдсан хоршоо 20, ХХК-20, төрийн бус байгууллага 6,нөхөрлөл 4, хуулийн этгээдийн мэдээлэлд нэмэлт өөрчлөлт оруулсан ХХК-30, хоршоо 30, боловсрол соёл сургалтын байгууллага 20, хуулийн этгээдийн лавлагаа олголт 10 тус тус хяналт шалгалт хийж илэрсэн алдаа зөрчлийг ХША-1 маягтаар тэмдэглэл хөтөлж, албан хаагчдад зөрчлийн тэмдэглэлээр хүргүүлж, засагдах боломжтой алдаа, зөрчлийг тухай бүр засч, засч ажиллалаа.

**Үнэт цаас зарцуулалтын хяналт, шалгалт**

Улсын бүртгэгч нарын үнэт цаас зарцуулалтад төлөвлөгөөт хяналт шалгалт хийсэн бөгөөд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасаг хүчингүй гэрчилгээ 2 гаргасан бусад зөрчил илрээгүй. Хуулийн этгээдийн улсын бүртгэгчээс алдаа илрээгүй. Иргэний улсын бүртгэгч нарын үнэт цаас зарцуулалтын тайлан, иргэний улсын бүртгэлийн статистик мэдээ зөрүүтэй, 11 сумын улсын бүртгэгчдийн үнэт цаасны тайлагналтад хяналт шалгалт хийхэд 3 сум алдаагүй, 9 сумын улсын бүртгэгчдийн тайлан мэдээ зөрүүтэй алдаа илэрсэн тул албан мэдэгдэл өгч илтгэх хуудсыг хүлээн авлаа.



**УБЕГ, Хэлтсийн даргын тушаалаар хийж гүйцэтгэсэн ажил**

1. Хэлтсийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 тушаалаар нярав Ц.Уртнасантай ажил хүлээлцлээ.

2. Хэлтсийн даргын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/23 тушаалаар Гурвансайхан сумын улсын бүртгэгч С.Сарантуяатай 2025 оны 12 дугаар сарын 27-ны өдөр ажил хүлээлцлээ.

3. Хэлтсийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/03 тоот Баримт бичиг нягтлан шалгах комисс томилох тушаалаар хяналтын улсын байцаагч, бичиг хэргийн эрхлэгч, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч, архивч гэсэн бүрэлдэхүүнтэй томилогдож байгууллагын албан хэрэг хөтлөлтийн ажлыг хууль, журмын дагуу явуулж байна. 2025 оны 04 дүгээр сарын 07 өдөр тус комисс хуралдаж, 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/05 тоот тушаалаар 2016 оны 01 сарын 05-ны өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийг дуустлах 4 нэр төрлийн 2111 хуудас баримт бичиг устгалаа.



4. Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2025 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн Б/586 тоот Б.Баянжаргалыг төрийн албанаас чөлөөлөх тухай тушаал, Улсын бүртгэлийн хэлтсийн даргын 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн А/04 тоот тушаалыг тус тус үндэслэн хяналтын улсын байцаагч Д.Нямсүрэн, ИУБТасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Б.Сайхантуяа, үнэт цаас бараа материал хариуцсан ажилтан Ц.Уртнасан нарын бүрэлдэхүүнтэй 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр Өндөршил сумын улсын бүртгэгч Б.Баянжаргалын ажлыг шинээр томилогдсон улсын бүртгэгч О.Амгалантөртэй ажил хүлээлцлээ.



5. Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2025 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн Б/436 тоот М.Уранцэцэгийг шилжүүлэх тухай тушаал, Улсын бүртгэлийн хэлтсийн даргын 2025 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн А/09 тоот тушаалыг тус тус үндэслэн хяналтын улсын байцаагч Д.Нямсүрэн, ИУБТасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Б.Сайхантуяа, мэдээлэл технологийн ажилтан Г.Алтан-Од нарын бүрэлдэхүүнтэй 2025 оны 08 дугаар сарын 12-ны өдөр Дэрэн сумын улсын бүртгэгч

М.Уранцэцэгийн ажлыг хүлээлцлээ.

6. 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр хэлтсийн өмч хамгаалах байнгын зөвлөл ТӨБЗГ-ын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 810 тоот “Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай” тогтоолоор 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр 2024 оны үндсэн хөрөнгийн тооллогоор илэрсэн цаашид ашиглах боломжгүй эвдэрч, хэмхэрсэн, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, машин тоног төхөөрөмж 36 ширхэг, 31.140.988.5 төгрөг, актлах тавилга эд хогшил 4 ширхэг 652.120 төгрөг нийт 40 ширхэг 31.793.108.5 төгрөгний үнэтэй актах хөрөнгийг акталж фото зургаар баримтлууллаа.

7. Улсын бүртгэлийн Ерөнхий газрын Бодлого төлөвлөлт, дүн шинжилгээний газраас 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдөр ирүүлсэн 7/7977 дугаартай тайлан ирүүлэх албан бичгээр ирсэн зөвлөмж, УБЕГ-ын Тамгын газраас ирүүлсэн 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 2/5452 дугаартай албан тоотоор ирүүлсэн журмуудыг тус тус хүлээн авч Дундговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн даргын 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн А/07 тоот тушаалаар “Байгууллагын албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх, үнэлгээний баг байгуулах.





тухай” үнэлгээний баг томилогож, 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдрөөс 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрүүдэд байгууллагын албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэллээ. Үнэлгээнд 20 албан хаагч хамрагдсанаас маш сайн үнэлгээтэй 13 буюу 65%, хэвийн үнэлгээтэй 4 буюу 20%, хангалтгүй үнэлгээтэй 3 буюу 15% байна.

4G төхөөрөмж ашиглан явуулын үйлчилгээ үзүүлсэн

Аймгийн Засаг даргын санаачилгаар төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, төрийн албан хаагч, иргэдэд тулгамдсан асуудлыг сонсох, шийдвэрлэх, тодорхой шийдэлд хүрэх зорилгоор “Асуудал шийдэл” уулзалтыг сумдад зохион байгуулсан бөгөөд Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчид уулзалтын үеэр хөдөө сумын иргэдэд бүртгэлийн

үйлчилгээг 4G төхөөрөмж ашиглан газар дээр нь хүргэж ажилласан. Энэ үйл ажиллагаанд бүртгэлийн хэлтсээс Хяналтын улсын байцаагч Баянжаргалан, Өндөршил, Дэрэн, Цагаандэлгэр, Луус, Адаацаг, Дэлгэрцогт, Луус, Дэлгэрхангай, Сайхан-Овоо, Эрдэнэдалай, Өлзийт, сумдын улсын бүртгэгч нарын иргэний бүртгэл хөтлөх үйл ажиллагаа, анхан шатны нотлох баримт, архивын баримтын эмх цэгц, архивласан байдал, цахим сангийн баяжилт, цахимжуулалт, үйлчилгээний стандартын чиглэлээр хяналт, шалгалтыг хийлээ. Нийт 659 бүртгэлд төлөвлөгөөт хяналт шалгалт хийлээ.



Сумдын бүртгэгч нарын үйл ажиллагаа харьцангүй ачаалал бага, алдаа зөрчил бага байсан бөгөөд арилгаж болох зөрчлийг тухай бүр засуулж цаашид алдаа гаргахгүй тал дээр анхаарч ажиллахыг зөвлөлөө. сумын улсын бүртгэгч нарын гаргаж байгаа нийтлэг алдаа нь бүртгэлийн цахимжуулалтад нотлох баримт дутуу цахимжуулах, нотлох баримт илүү авч цахимжуулах тодохолдол гарч байгаа тул 15 сумын бүртгэгч нарт цахим уулзалт зохион байгуулж арга зүйн зөвлөгөө өглөө.

Улсын бүртгэлийн хууль тогтоомжийг сурталчлах ажлын хүрээнд УБЕГазрын вэйбсайт болон фэйж хуудас, Улсын бүртгэлийн хэлтсийн фэйж хуудсанд байршигдсан мэдээ мэдээллийг шэйрлэж түгээхээс гадна иргэний үнэмлэхээ цаг хугацаанд нь авахад иргэдэд анхааруулсан reel, иргэний шилжилт хөдөлгөөн бүртгэлтэй холбоотой мэдээлэл 12 удаа бэлтгэн түгээхэд 3600 гаруй иргэн хандаж мэдээлэл авсан байна.

Хяналтын улсын байцаагчийн сар бүрийн статистик болон зөрчлийн тоон мэдээг хуулийн хугацаанд хүргүүлж ажиллалаа.

*Сургалт, сурталчилгаа:*

2025.01.27-нд Дундговь аймгийн прокурорын байгууллагаас зөрчил шалган шийдвэрлэдэг ЭБАТ нарт зөрчлийн тухай хуулийн хэрэглээ, зөрчил шалган шийдвэрлэхэд гардаг алдаа зөрчлийн талаар сургалт зохион байгуулж хэлтсийн дарга Ж.Өлзийжаргал, хяналтын улсын байцаагч Д.Нямсүрэн нар хамрагдлаа.

2025.08.02-нд Дундговь аймгийн Аудитын газарт 2024 оны зөрчил шалган шийдвэрлэсэн судалгааг гаргаж хүргүүлсэн.

## ***5-РТ. БИЧИГ ХЭРЭГ, АРХИВЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД:***

**Зорилт 1. Хэлтсийн бичиг хэрэг, дотоод архивын үйл ажиллагааг зохион байгуулна.**

Бичиг хэргийн дотоод үйл ажиллагаанд цахим сүлжээг бүрэн нэвтрүүлэх, ашиглах зорилгоор албан бичиг цахимаар солилцон, өргөдөл гомдлыг веб сайт, мэйл, фэйсбүүк групп, хуудсаар хүлээн авах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. Цаасаар ирсэн өргөдөл гомдлыг албан бичиг хөтлөлтийн EDOC системрүү бүртгэн холбогдох албан тушаалтанд цохсоноор тухайн албан хаагч цаг алдалгүй өөрт ирсэн бичгийг шийдвэрлэж байна.

2025 оны 11 дүгээр сарын 11-ны байдлаар нийт 749 албан бичиг ирснээс хугацаа хоцроосон албан бичиг байхгүй байна. 537 албан бичиг явуулсан бөгөөд хариутай 209 бичиг байна. Бичгийн баргдуулалт 100% шийдвэрлэлтийн дундаж 3 хоног байна.

Хэлтсийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт тайлан мэдээг хуулийн хугацаанд гарган хүргүүлэх ажлын хүрээнд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч, хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэж, өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд тавих дотоодын хяналтыг сайжруулан хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

| Өргөдөл, гомдлын төрөл | Тоо | Хувь | Дундаж хоног |
|---|---|---|---|
| Иргэний улсын бүртгэлийн үндсэн үйл ажиллагаа холбоотой | 7 | 44% | 2 |
| Хяналт шалгалтын үйл ажиллагаатай холбоотой | 7 | 44% | 7 |
| Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой | 2 | 12% | 3 |
| Улсын бүртгэлийн нэгдсэн архив | 0 | 0% | 0 |
| Ирсэн нийт хүсэлтийн тоо | 15 хүсэлт | | |
| Үүнээс хугацаа болоогүй | Байхгүй | | |
| Өргөдөл, гомдлын барагдуулалт | 100% | | |
| Нэг өргөдөл, гомдол шийдвэрлэсэн дундаж хоног | 5 хоног | | |




Иргэдийг чирэгдүүлэхгүй байх үүднээс өргөдөл, гомдлын хүлээн авах шат дараалллыг бууруулж Архив, бичиг хэргийн ажилтан холбогдох хууль журмын дагуу шууд хүлээн авч, удирдлагад танилцуулан, цохуулж холбогдох албан тушаалтанд өгч шийдвэрлэлтийн явцад хяналт тавин ажиллаж байна. 70593096 дугаартай утсаар иргэдээс иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбоотой мэдээллийг авч, иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд зөрчилтэй иргэд бичгээр хүсэлтээ гаргаж, шийдвэрлүүлж байна. Мөн байгууллагын сайт, цахим хуудсаар гомдол, санал, талархал хүлээн авч байна.

Хэлтсийн өргөдөл, гомдлыг хүлээн авсан төрөл, хэлбэр:

| Өргөдөл гомдлын төрөл | Ний | Хүлээн авсан хэлбэр | Ний |
|---|---|---|---|

| Мэдэгдэл | Гомдол | Санал | Хүсэлт | т | Биеэр | Утсаар | Цахимаар | 1111 | Бичгээр | т |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 |
| - | - | - | 15 | 15 | - | - | - | - | 15 | 15 |

Хэлтсийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал:

| Шийдвэрлэлтийн байдал | | | | | | | | | | Шийдвэрлэсэн дундаж хоног |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Шийдвэрлэж хариу өгсөн | | | | Бусад байгууллагад шилжүүлсэн | | Хугацаа хэтэрсэн /30 хоног/ | Сунгалт хийсэн /60 хоног/ | Хугацаа болоогүй | Шийдэх боломжгүй | |
| Бичгээр | Цахимаар | Утсаар | Биечлэн | Харьяаллын дагуу шилжүүлсэн | Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн | | | | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 |
| - | - | 5 | 10 | - | - | - | - | - | - | 5 хоног |

Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сангийн хөрвүүлэлтээс иргэдийн мэдээлэл алдаатай, орхигдсон учраас нас барсны бүртгэл, гэрлэлтийн бүртгэл мэдээллийн санд бүртгэлгүй тухай, шилжилт хөдөлгөөн, төрөлтийн бүртгэлд эцэг эхийн мэдээлэл ороогүй зэрэг зөрчилтэй холбоотой нийт 7 хүсэлт ирснийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын иргэний улсын бүртгэлийн газарт холбогдох материалыг хүргүүлснээр мэдээллийн санд иргэдийн мэдээллийг засвар болон нэмэлт өөрчлөлтийн бүртгэлээр залруулж оруулсан. Нотлох баримт нь бүрдсэн тохиолдолд хүсэлтийг 1 хоногт нь шийдвэрлэж байна.

Хяналтын улсын байцаагчид хандаж төрөлтийн мэдээлэл мэдээллийн санд оруулах хүсэлтийг хүлээн авч холбогдох нотлох баримтын бүрдүүлэлт хийхэд нэлээд хугацаа шаардагдаж, улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн УБЕГ-ын Хяналт шалгалтын газарт хүргэгдэн мэдээллийн санд засвар өөрчлөлт оруулан ажиллаж байна.

**Хэлтсийн дотоод архивын үйл ажиллагаа, зохион байгуулалт:**

Байгууллагын дотоод архивт хадгалагдаж байгаа цаасан баримт журнал бүртгэлүүдийг сэлбэн засварлаж үдэж цэгцлэн архивласан ба цэвэрлэгээ хадгалалт, хамгаалалт дотоод эмх цэгцийг сайжруулах ажлыг тогтмол хийж байна.

Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу тухайн оны баримтыг асуудал, сэдэвт холбогдох баримт бичгийн дараалаар төрөлжүүлэн дотоод архивт 2024 онд байнга хадгалагдах 11, түр хадгалагдах 59, 70 жил хадгалагдах 3, нийт 73 баримтыг хадгаламжийн нэгж үүсгэн хүлээн авсан.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2025.08.26 өдрийн А/153 дугаар тушаалын хүрээнд аймгийн хэлтсийн даргын 2025.09.04 өдрийн А/10 дугаар тушаалаар

ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсгийн даргаар архивч Э.Мөнхсумъяа, гишүүдээр мэдээлэл технологийн ажилтан Г.Алтан-од, Бичиг хэргийн эрхлэгч Б.Жанчивдорж, гэрээт архивч Г.Мөнхтуяа нар томилогдон архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгт бэлтгэх 24 заалт бүхий төлөвлөгөө батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан.

- Байгууллагын архив 94 баримтыг цэгцэлж хавтаслан хаягжуулсан, хадгаламжийн нэгжийн байрлалын заагуурыг шинэчилсэн.
- Байгууллагын архивын 2018-2024 оны байнгын баримтыг хянан нэг бүрчлэн бүрэн цахимжуулан цахим архив үүсгэсэн, түр хадгалах, 70 жил хадгалах баримтуудыг бүртгэн данс хөтөлж ажилласан.
- Бичиг хэрэг, архивын компьютерыг лиценз вирусийн эсрэг программ суулгасан.
- Цэвэрлэгээ үйлчилгээ, чийг дулааныг тогтмол хэмжин бүртгэл хөтлөн ажиллаж байна.



- Аймгийн төрийн архивт 2024  оны сонгуулийн баримтыг акт үйлдэн хүлээлгэн өгсөн.
- 2020-2024 он хүртэлх Хэвлэмэл хуудасны бүртгэл, Хэвлэмэл хуудасны эргэлтийн хэмжээг тооцон нөхөн бүртгэсэн.
- 2025 оны архивын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

БНШК-ын хурлаар хэлэлцэн хэлтсийн  үйл ажиллагааны явцад үүссэн баримт бичгийн хадгалах хугацааны жагсаалтаар хадгалах хугацаа нь дууссан, мэдээлэл лавлагаанд ашиглагдахгүй, архивын санд хадгалах шаардлагагүй иргэний маягт болон байгууллагын архивын түр хадгалах баримтыг устгах ажлыг зохион байгуулж жагсаалаар батлагдсан 80 нэр бүхий хэргийг устгалд оруулсан.



**Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд:**

Хаалганы хаягжуулалтыг шинэчилсэн байдал




Хавтасны хаягжуулалт




Самбарын хаягжуулалт






Тушаал, Явсан бичгийг үндэсний бичгээр хөрвүүлэн цахим болон цаасан хэлбэрээр хадгалж хэвшээд байна.



Удирдлагын академийн сургалтын нэгдсэн платформд байршуулсан цахим монгол бичгийн хичээлийг бие даан судлан хэлтсийн нийт 24 албан хаагч цахим бичвэрт суралцан сертификат авсан ба тогтмол 12 албан хаагч цахим бичиг боловруулан ажиллаж байна.



Удирдлагын академийн сургалтын нэгдсэн платформ (https://surgalt.gov.mn/)-д байршуулсан цахим хичээлийг судлан сертификат авсан албан хаагчдын мэдээлэл

Дундговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс

| № | Овог нэр | Албан тушаал | Анхан шат 10-р сарын 17 | Дунд шат 10-р сарын 31 | Ахисан шат 11-р сарын 14 |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 1 | Ж.Өлзийжаргал | Хэлтсийн дарга | - | - | №738665 |
| 2 | Д.Нямсүрэн | Хяналтын улсын байцаагч | №743158 | №743159 | №743160 |
| 3 | Л.Мөнхсарнай | ИУБ тасгийн дарга | №742864 | №750155 | №750156 |
| 4 | Б.Сайхантуяа | ХЭЗХЭУБ тасгийн дарга | №741807 | №750087 | №750143 |
| 5 | Е.Батбаяр | ИУБ улсын бүртгэгч | №742215 | №750139 | №750140 |
| 6 | Ш.Чулуунжаргал | ИУБ улсын бүртгэгч | Бүртгэл алдаатай орж болохгүй байгаа | | |
| 7 | Б.Одонтунгалаг | ХЭ улсын бүртгэгч | №745192 | | №745191 |
| 8 | О.Ганцэцэг | ЭХЭУБ улсын бүртгэгч | | | №745192 |
| 9 | Н.Үүгантуяа | ЭХЭУБ улсын бүртгэгч | №743470 | | №745193 |
| 10 | Х.Гарам | Ерөнхий нягтлан бодогч | №741700 | | №745194 |
| 11 | Э.Мөнхсувдаа | Архивч | №742387 | №742381 | №749991 |
| 12 | Г.Алтан-Од | Мэдээллийн технологийн ажилтан | №741881 | | №749992 |
| 13 | Ц.Уртнасан | Үнэт цаас хариуцсан ажилтан | №741072 | №747735 | №747801 |
| 14 | Б.Жанчивдорж | Бичиг хэргийн эрхлэгч | №739628 | | №747802 |
| 15 | Ш.Чулуун | Сайнцагаан сумын улсын бүртгэгч | №742190 | №745201 | №745197 |
| 16 | Э.Ариунбилэг | Адаацаг сумын улсын бүртгэгч | №741666 | №744438 | №750007 |
| 17 | Ж.Жамъяандорж | Баянжаргалан сумын улсын бүртгэгч | №743466 | | №750008 |
| 18 | Э.Одончимэг | Говь-Угтаал сумын улсын бүртгэгч | №743358 | №743362 | №749993 |
| 19 | З.Отгонжаа | Цагаандэлгэр сумын улсын бүртгэгч | №741556 | №741562 | №749994 |
| 20 | Ц.Гэрэлтуяа | Дэлгэрхангай сумын улсын бүртгэгч | | №743409 | №749995 |
| 21 | Ц.Отгонсүрэн | Сайхан-Овоо сумын улсын бүртгэгч | №741871 | №741898 | №742605 |
| 22 | Ч.Гантөгс | Эрдэнэдалай сумын улсын бүртгэгч | Бүртгэл алдаатай орж болохгүй байгаа | | |
| 23 | О.Амгаланбөр | Өндөршил сумын улсын бүртгэгч | №743009 | №748317 | №747380 |
| 24 | Г.Намжил | Дэлгэрцогт сумын улсын бүртгэгч | №741012 | №741014 | №747381 |
| | Нийт | | | | |













## ***НЭГ: УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ***

*1.1. 2025 онд дэвшүүлсэн зорилт*

2025 онд дэвшүүлсэн зорилтоо хэрэгжүүлэхийн тулд ажилдаа байгууллагын үйлчилгээний дараах стандартуудыг мөрдлөө. Үүнд:

- Иргэний бүртгэлийн үйлчилгээ болон архивтай холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх,
- Эд хөрөнгө, иргэний бүртгэл болон хуулийн этгээдийн архивын үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх,

· Бүртгэлийн үйл ажиллагааг иргэдэд түргэн шуурхай, шударга чирэгдэлгүй хүргэж, иргэн төвтэй бүртгэлийн үйлчилгээг бий болгох,

Мөн Улсын бүртгэлийн хууль, архивын стандарт, гарын авлага, заавар журмыг уншиж судалж эрхэлсэн ажилдаа мөрдлөг болгон, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлж, төрийн албан хаагчийн ёс зүй, ажлын цаг ашиглалтын үр дүнг сайжруулж, ажлын цагийг баримтлан ажиллаж байна.

## *ХОЁР: УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ*

### *2.1. Иргэний бүртгэлийн архивын үйлчилгээ*



Иргэний бүртгэлийн архивыг А-Я хүртэлх 28 үсгийн дараалалаар нь ангилан галиглаж нийт 1,622 хайрцагны 47,703 иргэний 146,768 хаатр Нас баралтын хувийн хэрэг нь 138 хайрцагны 12,435 иргэний 34,552 хаатр маягтууд архивд байрлагдаж байна.

2025 онд иргэний, гэр бүлийн бүртгэлийн (ИГББ) 8 төрлийн мэдээний ХААТР-Б маягтыг хүлээн авч хувийн хэрэгт галиглан шивж цахим санд оруулан, архивын санд байршуулан архивын эмх цэгцтэй байдлыг ханган ажилласан.

Мөн 334 ширхэг ИУБ ХААТР маягтуудын /А/ талыг Үсгийн дараалаар нь галиглан ангилан ялгаж нэг бүрчлэн шивж архивын ерөнхий газарт хүргүүлэн /Б/ тал нь архивт байрлагддаг.

Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл буюу иргэний шинэчилсэн бүртгэлд хамрагдсан дахин авсан ИУБ-31/Б/ маягтыг хувийн хэрэг тус бүрд нь байршуулдаг. ИУБ-31/А/ маягт 503 ширхэгийг иргэний баримтын төв архивд галиглан, шивж хавсралтын дагуу хүргүүлсэн.

Мөн архивын материалын хавтаслалт, хадгалалт, хамгаалалт дотоод эмх цэгцийг сайжруулах ажлыг тогтмол хийж байна. Архивт хадгалагдаж байгаа цаасан баримт журнал бүртгэлүүдүүдийнг сэлбэн засварлаж үдэж цэгцлэн архивалсан.

Улсын бүртгэгч нарт захиалгын дагуу иргэний бүртгэлийн хувийн хэрэг, болон журнал бүртгэлийг тухай бүр архиваас журнал хөтлөн хүлээлгэн өгч, буцаан авахдаа холбогдох хууль тогтоомжийг баримтлан ажиллаж, хугацаанд нь эргүүлэн авч архивд байршуулсан. Сумдын бүртгэгч нарт журналын хуулбарыг түргэн шуурхай шүүж өгч архивын үйлчилгээг үзүүлдэг.

Улсын бүртгэгч нарын засвар өөрчлөлт орсон ХААТР маягтуудыг хувийн хэргээс гарган конандаж журналд хөтөлгөө хийж бусад журналын хуулбарыг хавсарган гаргаж ХААТР маягтуудыг архивт буцаан авч байршуулсан. Хяналтын улсын байцаагчид төрөлтийн журналын хуулбар болон дүгнэлт гаргах цаасан суурьт ХААТР маягт 7 иргэний хувийн хэргийг гаргаж буцаан авч архивт байршуулсан.

Сумдаас татан авсан журнал бүртгэлүүдээс төрөлт, гэрлэлт, гэрлэлт цуцлалт, эцэг тогтоолт, нас баралт, үрчлэлт, овог нэр өөрчлөлт гэх мэт журналын хуулбарыг олшруулан өгч иргэдэд түргэн шуурхай үйлчилгээ үзүүлдэг. Сумдын бүртгэгч нарт архивын журнал бүртгэлийг шүүж хариу арга хэмжээ авч архивын үйлчилгээг үзүүлдэг..

Дундговь аймгаас бусад аймаг нийслэлрүү шилжин явсан 532 иргэний хувийн хэргийг тухайн шилжин суурьшиж байгаа аймаг нийслэл рүү галиглан шивж хүргүүлсэн. Мөн бусад аймаг нийслэлээс шилжин ирсэн 63 иргэдийн хувийн хэргийг архивт хүлээн авч тус бүрээр нь галиглан ангилан ялгаж жагсаалтын дагуу тулган авч архивд уутлан цахимжуулж ХААТР маягтуудыг нэрсийн үсгийн дарааллаар нь шивж байршуулан ажиллаж байна. 2025-онд иргэний гэр бүлийн бүртгэлийн эх нотлох цаасан суурьт баримт бичгийг цахимжуулах чиглэлийн дагуу 2019-2022 он хүртлэх ИУБ маягтыг архиваас түүвэрлэн гаргаж цахим санд оруулан цахимжуулан бүртгэгч нарт жагсаалтын дагуу архиваас бэлтгэн гаргаж ажилласан. Цахимжсан маягтын тоо 2494 байна.

Иргэний гэр бүлийн бүртгэлийн ИУБ маягтуудыг иргэний хувийн хэрэгт зохих журмын дагуу 2025 оны хагас жилээр архивлан байршуулсан. Үүнд :

- *ХААТР -11 /Төрсний бүртгэл/ - 112*
- *ХААТР -12 /Үрчлэлт/ - 5*
- *ХААТР -13 /Овог нэр өөрчлөлт/ - 10*
- *ХААТР -14 /Эцэг тогтоолт/ - 6*
- *ХААТР -15 /Гэрлэлт/ -30*
- *ХААТР -16 /Гэрлэлт цуцлалт - 13*
- *ХААТР-18 /Нас баралт/- 58*
- *ЗӨБ /Засвар өөрчлөлтийн бүртгэл/* - 0 нийт 234 ширхэг ХААТР маягтуудыг архивлан байршуулсан.

Архивын цахим мэдээллийн санд оруулахаар архиваас 75 ширхэг ХААТР маягтуудыг бүртгэгч нарт жагсаалтын дагуу гаргаж өгсөн.

*2.2. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ*



ЭХЭУБ-ийн архивт газрын бүртгэлтэй холбоотой 12711 ширхэг хувийн хэрэг, үл хөдлөх хөрөнгийн бүртгэлтэй холбоотой 4901 ширхэг хувийн хэрэг хадаглагдаж байгаа бөгөөд түүний хадгалалт хамгаалалтыг эмх цэгцтэй байлгаж, хувийн хэргийн нэмэлт хуудсуудыг тэмдэглэгээ хөтлөн хаягжуулж, архивын санд хадгалалт хамгаалалтын дүрэм журмын дагуу цэгцлэн, хаягжуулан байршуулж байна. Эхний хагас жилд 664 ширхэг ЭХЭУБ-ийн хувийн хэргийн маягтыг хадгалалт хамгаалалтын дагуу цэгцэлж байрлуулсан байна. Бүртгэгч бүрийн дэвтэрт тулгалт хийж хөтөлгөөг давхар хийж ажиллалаа.

Улсын бүртгэгч нараас хүлээн авч нэмэлт өөрчлөлт орж байгаа хувийн хэрэг бүрийг архивд хүлээн авч бичилт хийж хадгалалт хамгаалалтын хавтсанд байршуулан захиалгын хуудсаар олгож, тухайн өдөрт нь багтаан “архиваас түр олгох” ЭХЭУБ-ийн хувийн хэргийн бүртгэл /Маягт- А2/-д тэмдэглэл хөтлөн хүлээн авч, зориулалтын хавтаст хийн хувийн хэргийг тавиурт байрлуулж байна. Эд хөрөнгийн архивын хувийн хэргийг багтаамжийн дагуу цэгцэлж, нэмэлт өөрчлөлт орж буй хувийн хэргийг ангилан, хаягжуулж хайрцаглан байршуулсан.

2025 оны батлагдсан төлөвлөгөөний дагуу Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивын хувийн хэрэгт эд хөрөнгийн эрхийн Улсын бүтгэгч нарын нарын хамт эд хөрөнгийн архивын тооллого хийж дуусгалаа. Эд хөрөнгийн эрхийн архивын хувийн хэргийг тоолж тооллогоор нийт хувийн хэргийн тоо Г-12711, Ү- 4901 хувийн хэрэг тоологдсон байна. Тооллогын явцад байрлагдаагүй хувийн хэрэг болон нэмэлт өөрчлөлт орсон гар дээрх материалыг байршуулж архивын тавиур болон хувийн хэрэг доторх баримтуудыг эмхлэн цэгцэлж янзаллаа. Тооллогоор хувийн хэрэг давхардсан болон андуурагдаж хийсэн алдаа зөрчлүүд гарч дор бүр нь цэгцэлсэн. 3 давхрын архивын тавиурыг цэгцэлж 4 сумын хувийн хэргийг доод архивруу зөөж байршуулсан.

Эд хөрөнгийн архивын хавтаслалтыг шинэчилэн хийж архивын 6060 хувийн хэргийг хавтаслаж цэгцэлсэн.

*2.2. Хуулийн этгээдийн архивын бүртгэл*




*Хуулийн этгээдийн архив*

Хуулийн этгээдийн хувийн хэрэг, архивын тоо бүртгэлээр нийт 2,115 ширхэг байгаа бөгөөд бүртгэл, нэмэлт өөрчлөлт хийгдэн архивч орж байгаа хувийн хэргийг тухай бүр архивт байршуулж байна.

Хуулийн этгээдийн бүртгэлийн архив цахимжсанаар улсын бүртгэгч нар архиваас хувийн хэргийг өдөр тутам захиалж авахаа больж цахимаар нэмэлт өөрчлөлт оруулан архивын тэмдэглэл хөтлөн баримтыг буцаан авч байршуулах нөхцөл боломж бүрдсэн.

Шинээр өөрчлөлт орж буй хувийн хэрэгт тэмдэглэл хөтлөн архиваас гаргаж бүртгэгчийн гарын үсэг дугаарлалтаар нь хөтлөн архивлаж байршуулж байна.

2025 онд хуулийн этгээдийн бүртгэгч нь нийт 150 ширхэг хувийн хэрэгт нэмэлт өөрчлөлт оруулан архивт байршуулсан байна. Хувийн хэргийг тухай бүр архиваас гарган нэмэлт өөрчлөлт орсон тухай тэмдэглэл хөтлөн хөдөлгөөнд оруулсан байна. Хуулийн этгээдийн шинээр орж ирсэн 99 хувийн хэргийг тухай бүр байршуулан ажиллалаа.

Шилжин явсан хувийн хэрэг 2 шилжин ирсэн 3 хувийн хэргийг архивласан.Татан буугдсан хувийн хэргийн тоо 1

Хуулийн этгээдийн хүчингүй болсон 46 ширхэг тамга тэмдэг архивт хүлээн авсан Үүнээс татан буугдсан, хэлбэр өөрчилсөн, гэмтээсэн, нэр өөрчилсөн, гэх 8 тамгийг эхний хагас жилд устгалд оруулсан.

Хэлтсийн үйл ажиллагааны явцад үүссэн баримт бичгийн хадгалах хугацааны жагсаалтын дагуу хадгалах хугацаа нь дууссан, мэдээлэл лавлагаанд ашиглагдахгүй, архивын санд хадгалах шаардлагагүй болсон баримт, үндсэн хөрөнгийг өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар





хэлэлцэн акталж устгах ажлыг зохион байгуулсан.

## 6-РТ ТӨСӨВ САНХҮҮГИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ

Тус хэлтэс нь УБЕГ-ын даргын тушаалаар үндсэн 28, гэрээт албан хаагч 2, нийт 30 орон тоотой үйл ажиллагаа явуулж байгаагаас Хулд, Гурвансайхан, Дэрэн, Өлзийт сумдад Сумдад 4 орон тоо дутуу ажиллаж байна. Тус хэлтэс нь 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар Дундговь аймаг дахь Төрийн аудитын газраас “Түүвэрт” хамруулсан тул санал дүгнэлтгүй байхгүй.

УБЕГ-ын даргын 2025 оны 05-р сарын 07 өдрийн АНСДИТХ-ын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулах зардлын төсөв батлах тухай А/82 тоот тушаалаар 4,132.5 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч 100 хувь зарцуулсан. 2025 оны 1, 2, 3-р улиралд аймгийн төрийн сангийн хэлтсээс нийт 34,161.5 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтээр хүлээн авч хэлтсийн аймгийн төвийн 14 албан хаагчийн 2025 оны 1, 2, 3-р улирлын орон нутгийн нэмэгдэлд 1 албан хаагчийн үндсэн цалингийн 30-56.4 хувиар тооцож олгосныг 3, 6, 10-р сарын цалингийн 3-р хагас дээр бодож олгосон.

Өмнөх оны төсвийн хэмнэлтээс 27,450.0 мянган төгрөгийг Ахмадын санд шилжүүлж, 2025 оны 11 сарын 01–ны өдрийн байдлаар байгууллагын 11 ахмадад сар шинийн баяраар тус бүр 227.3 мянган төгрөгийн гарын бэлэг, тэтгэвэрт гарсан С. Сарантуяад өрхийн үйлдвэрлэл эрхлэхэд зориулж 2025 оны 1-р сард 5,000.0 мянган төгрөгийн нэг удаагийн

дэмжлэг, 2025 оны 10-р сард ахмадын баяраар 2,430.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл тус тус олгож нийт 9,930.0 мянган төгрөгийг зарцуулсан.

2025 оны 1, 2, 3-р улирлын санхүүгийн тайланг УБЕГ-ын СААХ-т Төсвийн тухай хуульд заасан цаглабарын дагуу дараа сарын 15-ны өдрийн дотор буюу хуулийн хугацаанд нь хүргүүлсэн. 2025 онд Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим системийг нэвтрүүлэх ажилтай холбогдон гарсан аймгийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/81 дүгээр захирамж, Орон нутгийн өмчийн газрын 2025 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн №33 тоот албан бичгийн дагуу байгууллагын өмчийн цахим систем нэвтрүүлэх ажлын хүрээнд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын программд 2024 оны жилийн эцсийн өмчийн мэдээ, захиргааны статистик маягтыг 2025 оны 4-р сарын 20- нд хугацаанд нь оруулж 100 хувийн гүйцэтгэлтэй ажилласан.

ТӨБЗГ-ын 2024 оны 12 сарын 30 өдрийн 810 тоот "Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай "тогтоолоор жилийн эцсийн тооллогоор илэрсэн цаашид ашиглах боломжгүй, эвдэрч, хэмхэрсэн, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, актлах машин тоног төхөөрөмж 36 ширхэг 31,140,988.5 төгрөг, тавилга эд хогшил 4 ширхэг 652,120 төгрөг нийт 40 ширхэг 31,793,108.5 төгрөгийн үнэтэй үндсэн хөрөнгийг данс бүртгэлээс хасаж байгууллагын ӨХБЗ-ийн хяналт дор аймгийн хогийн цэгт акталж устган фото зургаар баримтжуулан хэрэгжилтийг УБЕГ-ын СААХ, ТӨБЗГ-т 2025 оны 1-р улиралд багтаан хугацаанд нь хүргүүлсэн.

Батлагдсан төсвөөс 2025 оны 11-р сарын 1-ны өдрийн байдлаар 1,002,648.3 мянган төгрөгийн санхүүжилт авч цалин хөлсний зардалд 700,551.3 мянга, унаа хоолны зардалд 124,097.2 мянга, НДШ-д 102,894.1 мянга, байр ашиглалтын зардалд 4,080.0 мянга, бичиг хэргийн зардалд 8,218.4 мянга, тээвэр шатахуунд 3,007.1 мянга, шуудан холбоонд 1,512.8 мянга, бага үнэтэй, түргэн элэгдэх зүйлийн зардалд 2,115.9 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардалд 450.0 мянга, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл 165.0 мянга, мэдээлэл технологийн үйлчилгээний зардалд 1,958.0 нийт 949,049.9 мянган төгрөг зарцуулж, 53,598.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй төсвийн гүйцэтгэл 94.6 хувь байна. 2025 оны 05 дугаар сарын 31-ны өдөр Сангийн яамнаас улсын хэмжээнд бүх улсын төсөвт байгууллагын урсгал санхүүжилтийн үлдэгдэл мөнгийг татан авсан. Үүнтэй холбоотой тус хэлтсийн төрийн сангийн 100080012012 тоот дансны урсгал санхүүжилтийн үлдэгдэл болох 65,031.9 мянган төгрөгийг татан авсан болно. Үүнд орон тоо дутуу ажилласнаас үүссэн цалингийн зардлын хэмнэлт 50,752.1 мянга, НДШ-ийн зардлын хэмнэлт 6,696.6 мянга, гэрээ шинэчлэхтэй холбоотой шилжээгүй байсан байрны түрээсийн төлбөр болох 2,400.0 мянга, бусад зардлын бүлэг хооронд зохицуулалт хийгдэхээр хүлээгдэж байсан бусад зардлууд болох 5,183.2 мянган төгрөг байна.

Төсвийн гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал: /мянган төгрөг/

хүснэгт.




УБЕГ-аас тус хэлтсийн 2025 оны үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 80,000.0 мянган төгрөгөөр батлагдсан. 2025 оны 10-р сарын 31-ны өдрийн байдлаар орлогын төлөвлөгөөгөөр 66,666.6 мянган төгрөг бүрдүүлэхээс 70,843.0 мянган төгрөгийн орлого төвлөрч, үүнээс Сангийн яаманд 67,306.4 мянган төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөний биелэлт 106.3 хувь байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг нэр төрлөөр нь диаграммаар харуулбал: диаграмм. /мянган төгрөг/




Төсвийн гүйцэтгэлийн мэдээ болон үйлчилгээний орлогын 1-р сараас 10-р сарын мэдээг тус бүр 10 удаа УБЕГ-т хүргүүлсэн. Нийгмийн даатгалын шимтгэлийн 1-р сараас 10-р сарын тайланг сар бүр нийт 10 удаа, 2024 оны 4-р улирал, 2025 оны 1, 2, 3-р улирлын татварын тайланг цахимаар тоон гарын үсгээр баталгаажуулан улирал бүр гаргаж харьяа байгууллагуудад хугацаанд нь хүргүүлсэн.

Тус хэлтэс нь 2025 оны 10 сарын 31-ний өдрийн байдлаар УБЕГ-с төрсний гэрчилгээ 600, төрсний гэрчилгээний хавтас 500, гэрлэлтийн гэрчилгээ 100, гэрлэлтийн гэрчилгээний хавтас 200, нас барсны гэрчилгээ 300, нас барсны гэрчилгээний хавтас 250,

биеийн давхцахгүй өгөгдлийн маягт 3000, газар өмчлөх эрхийн гэрчилгээ 1000, үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ 900, хуулийн этгээдийн гэрчилгээ 900, ЭХЭУБ-н хувийн хэргийн хавтас 300, нийт 13 нэр төрлийн 7850 ширхэг тусгай зориулалттай бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авсан.

2025 оны 10 сарын 31-ний өдрийн байдлаар төрсний гэрчилгээ 640, төрсний гэрчилгээний хавтас 640, гэрлэлтийн гэрчилгээ 90, гэрлэлтийн гэрчилгээний хавтас 90, нас барсны гэрчилгээ 241, нас барсны гэрчилгээний хавтас 241, үндсэн бүртгэлийн маягт 390, шилжилт хөдөлгөөний маягт 811, биеийн давхцахгүй өгөгдлийн маягт 1710, газар өмчлөх эрхийн гэрчилгээ 950, үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ 700, хуулийн этгээдийн гэрчилгээ 300 ширхэгийг тус тус зарцуулж, төрсний гэрчилгээ 100 , төрсний гэрчилгээний хавтас 83, гэрлэлтийн гэрчилгээ 200, гэрлэлтийн гэрчилгээний хавтас 175, нас барсны гэрчилгээ 179, нас барсны гэрчилгээний хавтас 112, үндсэн бүртгэлийн маягт 1090, шилжилт хөдөлгөөний маягт 1029, биеийн давхцахгүй өгөгдлийн маягт 1300, газар өмчлөх эрхийн гэрчилгээ 50, үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ 200, хуулийн этгээдийн гэрчилгээ 400, нийт 12 нэр төрлийн 4918 ширхэг тусгай зориулалттай бараа материалын үлдэгдэлтэй байна.

Тусгай зориулалттай бараа материалын хөдөлгөөнийг графикаар харуулбал:




2025 оны 10 сарын 31-ний байдлаар нийт 89 ширхэг үнэт цаас хүчингүй болсны 15 ширхэг нь техникийн алдаанаас, 74 ширхэг нь улсын бүртгэгчийн алдаанаас хүчингүй болсон байна.

Хүчингүй болсон үнэт цаасыг нэр төрлийг хүснэгтээр харуулбал:




Шилэн дансны тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу 2025 оны 01 дүгээр сарын 01-ээс 11 дүгээр сарын 01 өдөр хүртэлх хугацаанд 139 мэдээллийг 100 хувь байршуулсан. Үүнээс мэдээлээгүй мэдээлэл 0, хугацаа хоцорсон төлөвтэй мэдээлэл 0, хугацаандаа байршуулсан 139 мэдээлэлтэй, 100 хувийн гүйцэтгэлтэй ажиллаж байна.

Тус хэлтэс нь 2025 оны 11 дугаар сарын 01-ны өдрийн байдлаар байр ашиглахтай холбоотой зардлын санхүүжилт дутуу орж ирсэн мөн 2025 оны 05 дугаар сарын 1-ны өдрийн “Орон нутгийн өөрийн өмчийн түрээсийн гэрээ” №12 тоот шинэчилсэн гэрээтэй холбоотой 2025 оны 12-р сарын хүлээгдэж буй гүйцэтгэлээр байрны түрээсийн 3,384.4 мянган төгрөг, бусад нийтлэг АҮТХураамж /210801/ зардлыг 2025 оны 4-р сарын 1-ээс хойш санхүүжүүлээгүй тул байрны цэвэрлэгээний хөлс 2025 оны 4-р сараас хойш төлөгдөөгүй 1,350.0 мянган төгрөг, нийт 4,734.4 мянган төгрөгийг өртэй байна. Уг өр төлбөрийг барагдуулахаар УБЕГ-ын СААХ-т 12-р сарын төсвийн хуваарьт өөрчлөлт оруулж тусгахаар санал хүргүүлэн, жилийн эцсийн санхүүгийн тайлангаар өр төлбөргүй байхаар ажиллаж байна.

## ШИНЭЛЭГ АЖИЛ:

Монгол Улсад бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний 85 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулах ажлын хүрээнд иргэдэд чиглэсэн шинэлэг ажил зохион байгуулах, албан хаагчдыг сэдэлжүүлэхэд зорилгоор хэлтсийн албан хаагчдыг 4 багт хуваан 2025.05.19 өдрөөс 2025.06.29 хүртэлх хугацаанд хамаарах сэдвийн хүрээнд иргэд олон нийтийг уриалсан шинэлэг мэдээлэл хүргэсэн ажил зохион байгуулан ажиллаж байна.






2025 онд Говь-угтаал, Өлзийт сумд орон нутгийн санхүүжилтээр /50,0 сая төг/ киоск машин суурилуулж 24/7 үйлчилгээ нэвтрүүлсэн.





Хэлтсийн үйл ажиллагаанд шинэ суурин компьютер 2ш, гурван үйлдэлт принтер 3ш УБЕГазраас хангасан






Албаны хэрэгцээнд зориулж хяналтын камер, свич шаардлагатай төхөөрөмжүүдийг төсөвт багтаан хангалт хийж хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцлийг хангаж ажиллалаа.





Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 11000 хувийн хэргийн гадна хавтсыг сольж шинэчлэн хийсэн.



✓ Тус хэлтсийн залуучуудын хөгжлийн зөвлөлөөс санаачлан 2025 оны 1-р улиралд стандарт мөрдөх сарын аян зохион байгуулж 2025.02.10- 2025.02.17 хугацаанд “Бурмаар тэтгэхээр Урмаар тэтгэ’ долоо хоног болгон зарлаж хэлтсийн албан хаагчид цахимаар болон захидлаар бие биедээ сэтгэгдэл мэдрэмжээ хуваалцан долоо хоногийн эцэст дүгнэн нэгдсэн сургалт зохион байгуулсан.





✓ Мөн дээрх аяны хүрээнд албан хаагчид дотнын хүндээ чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлж хүргүүлсэн.



✓ Стандарт мөрдөх сарын аяны хүрээнд “Санхүүгийн сахилга бат”-ын долоо хоног зарлан хэлтсийн даргын зүгээс сургалт зохион байгуулж нийт албан хаагчид хуримтлалтай болж өдөр бүр сонирхолтой даалгавар гүйцэтгэн хамгийн хамгийн шалгаруулсан.








✓ 2025.02.03 өдрөөс 2025.02.28 хугацаанд “Эртэч шувуухай’ аян зарлан мөн хамгийн хамгийн аа шалгаруулсан.












✓ Ажлын байрны соёл, стандартыг сайжруулах 5S зарчмыг албан хаагчдад мэдээлэл хүргэн танилцуулж, өрөө, тасалгаа, нэг цэгийн үйлчилгээний танхимд их цэвэрлэгээ зохион байгуулан ажиллаа.










2. Хэлтсийн алба хаагчид баруун зүүн сумдаар хуваагдан бүртгэлийн үйлчилгээ үзүүлж ажиллаа.












Өлзийт сумын буянт багт хөдөлгөөнт 4жи төхөөрөмжөөр улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлж иргэдээс санал хүсэлт авч контент бэлтгэн ажиллалаа.

ü [https://www.facebook.com/reel/2955398404665624](https://www.facebook.com/reel/2955398404665624)




Аймгийн Засаг даргатай хамтран ажиллаж хөдөөгийн 15 сум алслагдсан 2 багт хүрч ажиллан зөөврийн төхөөрөмжөөр бүртгэлийн үйлчилгээг 930 иргэнд уулзалтын танхимд газар дээр нь үзүүлж, 1500 орчим иргэнд мэдээлэл, зөвлөгөөг өгч ажилласан бөгөөд хөдөөгийн малчид иргэдээс талархал илэрхийлсэн. Мөн аймгийн удирдлагын зүгээс аймаг орон нутгийн бодлого зорилтыг дэмжин хамтран ажилласан талархаж албан хаагчдын томилолтын зардал, унаа, хоол, байрыг бүрэн шийдвэрлэлээ. Тус хэлтсийн үйлчилгээний танхим байршуулсан талархлын самбарт 10,11 сaруудад талархал илэрхийлсэн хуудас 36 ш байршсан байна. хөдөө сумдад тогны хязгаарлалт их байх тул мотор ажиллуулан үйлчилгээг хэвийн үзүүлсэн нь иргэдэд ихээхэн сайшаагдсан. https://www.facebook.com/share/v/1HQpjazi81/














Иргэдийн санал хүсэлт хүлээн авч байгаа мэдээллийн сувгуудын талаар постер бэлтгэн аймаг, байгууллага, салбар зөвлөлийн цахим хуудсаар иргэдэд түгээх.










ЕС. Байгууллагууд үйл ажиллагааны чиглэлээр 2-оос доошгүй удаа санал асуулга авч гарсан санал, тулгамдаж байгаа асуудлыг нэгтгэн, хэрхэн шийдвэрлэсэн талаар иргэдэд мэдэгдэж эргэх холбоотой ажиллах.

- ✓ Хэлтсийн мэдээллийн ил тод байдлын самбар, вэб сайт, сошиал хуудас болон erp системээр сэтгэл ханамжийн судалгаа бөглөх qr код хүргэн ажиллаж байна. Мөн тус аяны хүрээнд иргэдээс ярилцлага авч цахим хуудаст байршуулсан. Бичлэгийн линк хавсаргав.

















- ✓ https://www.facebook.com/reel/651238384551009
- ✓ https://www.facebook.com/reel/622727624263744
- ✓ https://www.facebook.com/share/v/1AK7tL58op/
- ✓ https://www.facebook.com/share/v/16FwcZ7Nt4/

2025 оныг Ёс зүй, хариуцлагыг сайжруулах жил болгон зарлаж Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ баримтлан сахилга хариуцлагатай, шинийг санаачлан ажиллахаар гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган ажиллаж байна. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулиар цахим контент хийж нийтэд түгээсэн. Үйлчлүүлэгч иргэдээс санал, сэтгэгдлийг авч үйл ажиллагаандаа дүгнэлт хийн ажиллалаа. Бүртгэлийн багц хуулийн өөрчлөлтөд тусгах саналыг УБЕГазарт хүргүүллээ.

Бүртгэлийн хууль тогтоомжийн талаар шинээр 16 насанд хүрч иргэний үнэмлэх авч байгаа 68 хүүхдэд “Амьдралын алтан босго-16 нас” өглөөлөг зохион байгуулж мэдээлэл өгч байгууллагын үйл ажиллагаатай танилцууллаа.

Төрийн албан хаагчийн ёс зүйн талаар бэлтгэсэн хэлтсийн цахим контенттой дараах линкээр орж танилцах боломжтой. http://dundgovi.burtgel.gov.mn/post/66699






Цахим орчинд тус хэлтсийн зүгээс “Ёс зүйгээр үлгэрлэе” зурагт хуудас байршуулан нийт төрийн албан хаагчдыг нэгдэхийг уриалж аймгийн хэмжээнд нөлөөлөл үзүүлэн ажилласан байна. https://www.facebook.com/share/v/1A7Y9czYRD/









БАТЛАВ
ДУНДГОВЬ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Ж.ӨЛЗИЙЖАРГАЛ
2025 оны 09 дугаар сарын 01

“ЁС ЗҮЙГЭЭР ҮЛГЭРЛЭЕ” АЯНЫ УДИРДАМЖ

2025 оны 09 дугаар сарын 01 Мандалговь хот

Нэг. Аяны зорилго

1.1 Улсын бүртгэлийн байгууллагын түүхт 85, Бүртгэлийн нэгдсэн тогтолцоонд шилжсэний 16 жилийн ой, "Улсын бүртгэлийн ажилтны өдөр"-ийг угтан Улсын бүртгэлийн байгууллагын төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын 2025 оны төлөвлөгөөний дагуу байгууллагын дотоод соёлд ёс зүйн үнэт зүйлийг төлөвшүүлэх, ажлын орчинд харилцан хүндлэл, шударга ёсыг дэмждэг, улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд хүргэхдээ Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон бусад холбогдох дүрэм журмыг баримталдаг, удирдлага, хамт олны уур амьсгал эерэг, харилцаа хандлагадаа анхаардаг зорилтыг хангахад оршино.

Хоёр. Хамрах хүрээ

2.1 Дундговь аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн нийт албан хаагчид оролцоно.

Гурав. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

| № | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Хугацаа | Хариуцах албан хаагч |
|---|---|---|---|
| 1 | Эмэгтэй энерги сургалт | 2025.10.17 | Б.Одонтунгалаг<br>Ц.Уртнасан<br>Б.Сайхантуяа |
| 2 | Ёс зүйтэй хамт олон танилцуулга | 2025.10.20 | Ш.Чулуунжаргал<br>Л.Мөнхсарнай<br>Б.Одонтунгалаг<br>Э.Мөнхсумъяа |
| 3 | Гэр бүлийн өдөр спорт арга хэмжээ | 2025.10.28 | Гэр бүлийн зөвлөл |
| 4 | Төрийн албаны ёс зүй | 2025.10.21 | Хэлтсийн дарга |
| 5 | Ёс зүйгээр манлайлъя | 2025.10.29 | Хэлтсийн дарга |
| 6 | Ёс зүй, харилцаа хандлагын талаар мэдээлэл, видео, контент хийж байгууллагын цахим хуудсаар сурталчлах. | 2025.10.17 | Ёс зүйн зөвлөл<br>Залуучуудын зөвлөл |

ХЭЛТСИЙН ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛ, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛ

Хэлтсийн албан хаагч эмэгтэйчүүдэд өөрийгөө хөгжүүлэх, эмэгтэй энергээ сэргээх, харилцаандаа юуг анхаарвал зохих талаар чөлөөт ярилцлагыг удирдлагын зүгээс дресс кодтой зохион байгуулж урам зоригийг сэргээсэн үйл ажиллагаа зохион байгууллаа. Өрх гэр, ажлын байр, цаашлаад орон нутаг нийгэмдээ үлгэрлэн манлайлах талаар ярилцаж өнгөрүүллээ.



Ажлын байрны дасгалыг тогтмолжуулах аян зарлаж байгууллагын нярав зохион байгуулан 10 минутын дасгал хөдөлгөөн хийж хэвшүүлж байна. Энэ цагт үйлчлүүлж байгаа иргэд хамтран дасгал хийж байгаа нь иргэдэд ч эерэг уур амьсгалыг түгээж байна. Удаан хугацаагаар компьютер ширтдэг албан хаагчид нүдний дасгал хийж хэвшээд байна.








Олон улсын амадын өдрөөр нийт ахмадуудыг урьж дурсамж уулзалт зохион байгуулж нөлөөллийн өдөрлөг зохион байгууллаа. Бүртгэлийн салбарт ажиллаж байх хугацааны дурсамж сэргээж  улсын хэмжээний томоохон далайцтай ажлуудыг гүйцэтгэсэн тухай, багаар ажиллахад анхаарах асуудлын талаар болон хувь хүн баг дотор өөрийгөө хэрхэн хөгжүүлэх, төрийн албан хаагчийн манлайлах чадварын талаар чөөлөөт ярилцлага зохион байгууллаа.





Улсын бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай найдвартай, чирэгдэлгүй, чанартай, хүртээмжтэй хүргэхдээ төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон бусад холбогдох дүрэм журмыг баримтлан, удирдлага хамт олны уур амьсгал эерэг, харилцаа хандлагадаа анхаарах зорилгоор хувцас жигдрэлт, үс засалт, харилцаанд анхааран "СТАНДАРТ МӨРДӨХ АЯН"-ыг хэлтэстээ өрнүүлэн ажиллаж байна.



БАТЛАВ:
ДУНДГОВЬ АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Ж.ӨЛЗИЙЖАРГАЛ
2025 оны 08 дугаар сарын 27

СТАНДАРТ МӨРДӨХ АЯН

ЗОРИЛГО:

Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний стандарт, үйлчилгээг иргэн хуулийн этгээдэд шуурхай найдвартай, чирэгдэлгүй, чанартай, хүртээмжтэй хүргэхдээ төрийн албан хаагчийн ёс зүйн тухайн хууль болон бусад холбогдох дүрэм журмыг баримталдаг, удирдлага хамт олны уур амьсгал зэрэг, харилцаа хандлагадаа анхаардаг зорилтыг хангахад оршино.

ЗОРИЛТ:

1. Хэлтсийн албан хаагчид үйлчилгээний зарчмыг дагаж мөрдөнө.
2. Хэлтсийн ажилтанд тавигдах шаардлагыг хангаж ажиллана.
3. Хэлтсийн үйлчилгээний танхимд тавигдах шаардлагыг мөрдөнө.
4. Хэлтсийн танхимаар үйлчилгээ үзүүлэхэд тавих ерөнхий шаардлагыг мөрдөнө.
5. Хэлтсийн үйлчилгээ үзүүлэх алхмыг дагаж мөрдөнө.

АЯНЫ ХҮРЭЭНД ХЭЛТСИЙН АЛБАН ХААГЧ ДУНД:

| № | Хувцас жигдрэлт | | | | |
|---|---|---|---|---|---|
| | I өдөр | II өдөр | III өдөр | IV өдөр | V өдөр |
| 1 | Бүртгэлийн цагаан цамц, хар /хөх/ юбка, өсгийтэй туфль | Цагаан эсвэл цэнхэр цамц, өмд, юбка, өсгийтэй туфль | Бүртгэлийн цагаан цамц, хар /хөх/ юбка, өсгийтэй туфль | Цагаан эсвэл цэнхэр цамц, өмд, юбка, өсгийтэй туфль | Бүртгэлийн цагаан цамц, хар /хөх/ юбка, өсгийтэй туфль |
| 2 | Бүртгэлийн цагаан цамц, брюкин өмд, ботинк | Цагаан эсвэл цэнхэр цамц, брюкин өмд, ботинк | Бүртгэлийн цагаан цамц, брюкин өмд, ботинк | Цагаан эсвэл цэнхэр цамц, брюкин өмд, ботинк | Бүртгэлийн цагаан цамц, брюкин өмд, ботинк |
| 3 | Жич: Үсийг дээш нь бантагтай хавчаараар шууж боох | | | | |

ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛ



“Ажил хэрэгч хувцаслалт - Ажлын бүтээмж” - нөлөөллийн арга хэмжээг хэлтсийн удирдлагын зүгээс зохион байгуулж шинээр батлагдсан лого бүхий зангиа, ажлын үнэмлэхийг нийт албан хаагчдад бэлэглэж ажлын өглөөг зэрэг уур амьсгалыг эхлүүлэв.Хэн нэгний жижигхэн сэтгэл, ганц үг ажлын бүтээмжийг, ажлын байрны уур амьсгалыг өөрчилж чаддаг болохыг бодитоор харуулсан нөлөөллийн ажил.













Хамт олны дунд талархлын 7 хоног зарлаж албан хаагчид нэг нэгэндээ талархал илэрхийлэх, захидал бичих, баярлуулах идэвхжүүлэлтийн үйл ажиллагааг хэлтсийн залуучуудын зөвлөлөөс зохион байгуулж эерэг уур амьсгалыг хамт олны дунд үүсгэж “Ажил амьдралын тэнцвэр” сэдвээр сургалт хийв.





Хайр түгээе аяны хүрээнд хэлтсийн хамт олон Улаан загалмайн хороотой хамтран ажлын байранд, хамт олондоо, гэр бүлдээ эерэг уур амсгал түгээх нөлөөллийн арга хэмжээ зохион байгууллаа.






**ТАЙЛАН НЭГТГЭСЭН**

**ХЭЛТСИЙН ДАРГА** **/Ж.ӨЛЗИЙЖАРГАЛ/**